

# **Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалах эрхийг баталгаажуулах нь**

Мэргэжлийн сургалтын цуврал N°29



Улаанбаатар хот 2007

---

*Орчуулсан:*

*Тунхаглалыг орчуулсан:*

*Хянасан:*

**Идрэн Д.Оюунсүрэн**, МУИС-ийн  
ОУХС-ийн багш

**С. Ганчимэг**, Монголын Эмнести  
Интернэшнлийн удирдах зөвлөлийн  
гишүүн

**Сарта-Уул Б.Алтантуяа**, Монголын  
Эмнести Интернэшнлийн Гүйцэтгэх  
захирал

---

*Энэ номыг доорхи хаягаар хандаж Монголын Эмнести  
Интернэшнлээс үнэгүй авч болно.*

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу - 44, 10 тоот  
Утас/факс: 976-11-324705  
И-мэйл: aimncc@magicnet.mn  
www.amnesty.mn



---

## ГАРЧИГ

ТОВЧЛОЛ .....	6
ТАНИЛЦУУЛГА .....	7

### I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫН ТУХАЙ

A. Хүний эрхийг хамгаалагчид юу хийдэг вэ?.....	8
1. Хүн бүрт хүний эрхийг .....	8
2. Хаа сайгүй хүний эрх .....	9
3. Орон нутгийн Үндэсний бус нутгийн болон олон улсын үйл ажиллагаа .....	9
4. Хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлэл цуглуулах, түгээх .....	9
5. Хүний эрхийг хохирогчдод дэмжлэг үзүүлэх .....	10
6. Хариуцлагыг дээшлүүлэх, шийтгэл хүлээхгүй байхыг таслан зогсоох .....	10
7. Сайн засаглал ба засгийн газрын бодлогыг дэмжих .....	11
8. Хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэнд хувь нэмрээ оруулах .....	11
9. Хүний эрхийн боловсрол, сургалт .....	11
B. Хэн хүний эрхийн хамгаалагч болж чадах вэ .....	12
1. Мэргэжлийн үйл ажиллагаагаараа хүний эрхийг цалинтай болон сайн дураараа хамгаалах .....	13
2. Мэргэжлийн бус хүрээнд хүний эрхийг хамгаалах нь .....	15
B. Хүний эрхийн хамгаалагчдад тавигдах наад захын шаардлага гэж бий юу .....	16

### II. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫН ЭСРЭГ ГАРДАГ ЗӨРЧИЛ, ТЭДЭНД ТОХИОЛДДОГ БУСАД БЭРХШЭЭЛ

A. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зөрчлийн жишээ .....	19
B. Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн нөхцөл байдал .....	22
B. Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг зөрчил өдүүлэгчид .....	24
1. Төрийн удирдах байгууллага .....	24
2. Төрийн бус оролцогчид .....	25

---

3. Төрийн ба төрийн бус оролцогчдын эерэг үүрэг роль .....	26
--	----

### **III. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ НҮБ ХЭРХЭН ХАМГААЛДАГ БОЛОН ТЭДНИЙ АЖИЛД ҮЗҮҮЛДЭГ ДЭМЖЛЭГ**

A. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал .....	28
1. Эрх зүйн чадамж .....	28
2. Тунхаглалын заалт .....	29
а/ Хүний эрхийн хамгаалагчдад олгох эрх ба хамгаалалт ..	29
б/ Улсуудын хүлээх үүрэг .....	30
в/ Хүн бүрийн хүлээх хариуцлага .....	31
г/ Үндэсний хууль тогтоомжийн үүрэг .....	31
Б. Ерөнхий нарийн бичгийн даргын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн тусгай төлөөлөгч .....	32
1. Тусгай төлөөлөгчийн албан ёсны бүрэн эрх .....	32
2. Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаа .....	32
а/ Хүний эрхийг хамгаалагчидтай харилцах .....	33
б/ Улсуудтай харилцах .....	33
в/ Бусад чухал оролцогчидтой харилцах .....	34
г/ Тодорхой тохиолдлууд .....	34
д/ Улс оронд айлчлах .....	35
е/ Семинар, бага хурал .....	36
д/ Стратеги .....	36
е/ Тайлан, илтгэлүүд .....	37
3. Хангамжийн болон нөөцийн зохицуулалт – ХЭДКГ-ын үүрэг .....	37

### **IV. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ АЖЛАА ХИЙХЭД НЬ ХЭРХЭН ДЭМЖИЖ, ХАМГААЛАХ ВЭ?**

A. Улсуудын үйл ажиллагаа .....	39
1. Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалыг хэрэглэх .....	40
2. Бодит байдал дээрх хамгаалалт .....	40
3. Төрийн байгууллагын авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа .....	41
Б. Төрийн бус оролцогчид тэр дундаа иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхний үйл ажиллагаа .....	42
В. НҮБ-ын газар, хэлтэс, төрөлжсөн байгууллага, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа .....	43
1. Үндэсний хэмжээнд .....	44

---

2. Бүсийн болон олон улсын түвшинд .....	45
Г. Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаа .....	45
1. Ажлын чанар .....	45
2. Сургалт .....	46
3. Харилцаа холбооны сүлжээ, суваг .....	46
4. Дүн шинжилгээ .....	47
5. Хүний эрхийн асуудлаар төрөөс үзүүлэх хамгаалалтыг сайжруулах .....	47
6. Хамгаалалтын стратеги .....	47
7. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг хэрэглэх .....	47

## **ХАВСРАЛТ**

I. Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал .....	48
II. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг зөрчсөн үйлдлийн талаар Тусгай төлөөлөгчид гомдол гаргах зааварчилгаа .....	56
III. Хүний эрхийн мэргэжлийн сургалтын цувралын жагсаалт .....	60

---

## ТОВЧЛОЛ

ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
НҮБХЭДКГ	НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар
НҮБ ДОХХ	НҮБ-ын ДОХ-ын Хөтөлбөр
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
НҮБДДКГ	НҮБ-ын Дүрвэгсэдийн Дээд Комиссарын Газар
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн Сан
ЮНИФЕМ	НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сан
ДХХ	Дэлхийн Хүнсний Хөтөлбөр
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

## ТАНИЛЦУУЛГА

Хүний эрхийг хамгаалагчдын үнэлж баршгүй үйл хэргийг дэмжих зорилгоор энэхүү гарын авлагыг туурвисан бөгөөд төрийн захиргааны байгууллага, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллага, НҮБ-ын албан хаагчид, хувийн хэвшлийнхэн (түүний дотор үндэстэн дамнасан корпораци) болон мөн хүний эрхийг хамгаалагчдад өөрсдөд нь зориуллаа. Түүнчлэн энэхүү гарын авлага нь хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал, гүйцэтгэж буй үүргийн талаархи мэдээллийг түгээж байдаг, сэтгүүлчид болон бусад хүмүүст зориулагдсан юм. Тодруулбал:

- Хүний эрхийг хамгаалагчидтай зайлшгүй харьцдаг засгийн газрууд болон янз бүрийн мэргэжилтнүүдэд “хүний эрхийг хамгаалагч” гэж хэн болох, тэд ямар үйл ажиллагаа явуулдаг талаар тодорхой ойлголт өгөх;
- Хүний эрхийг хамгаалах эрхийг дэмжих;
- Хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагаанд нь учирч байгаа аливаа дарамт шахалтаас хамгаалах;
- Хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийн болон сургалтын үйл ажиллагаа явуулахад нь гарын авлага болгох зэрэг зорилго тавьсан юм.

Түүнчлэн уг гарын авлагад “Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал”<sup>1</sup>-ын тухай товч дүгнэлтийг багтааснаас гадна НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаа, ажлын арга хэлбэрийн талаар танилцуулсан болно. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд хүн бүр хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ хэмээн заасан. Тийм ч учраас энэхүү гарын авлага хамгийн гол нь хүний эрхийг хамгаалахад илүү олон хүнийг татан оролцуулж, хүний эрхийг хамгаалагч болоход нь урам зориг өгөх зорилт тавьсан билээ.

Н  
СУДАЛГААНЫ САН

---

<sup>1</sup> Цаашид “Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал” гэнэ. Уг тунхаглалыг “Хавсралт 1”-ээс үзнэ үү.

---

# I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫН ТУХАЙ

“Хүний эрхийг хамгаалагч” гэдэг нь бие дааж буюу бусадтай хамтран хүний эрхийг хамгаалах буюу хөхиүлэн дэмжих талаар ажиллаж байгаа хүнийг хэлнэ. Хүний эрхийг хамгаалагчийг юуны өмнө хийж буй ажлаар нь тодорхойлж болох бөгөөд ямар үйл ажиллагааг (А хэсгийг үзнэ үү) ямар хүрээнд явуулж байгаагаар нь (Б хэсгийг үзнэ үү) хамгийн сайн тодорхойлж чадна. Хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны талаарх дараах жишээнүүд бүрэн гүйцэд жагсаалт биш гэдгийг анхаарна уу.

## A. Хүний эрхийг хамгаалагчид юу хийдэг вэ?

### 1. Хүн бүрт хүний эрхийг

Хүний эрхийг хамгаалагч байхын тулд тухайн хүн хувь хүн буюу бүлэг хүмүүсийн нэрийн өмнөөс хүний эрхийн аливаа асуудлаар үйл ажиллагаа явуулах чадвартай байх ёстой. Хүний эрхийг хамгаалагчид иргэний болон улс төрийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн сацуу эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг ч хамгаалах, хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

Хүний эрхийг хамгаалагчид цаазаар авах ял, эрүүдэн шүүлт, хууль бусаар баривчилж хорих, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, ялгаварлан гадуурхалт, хөдөлмөрийн асуудал, хүчээр нүүлгэн шилжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хортой хог хаягдал, түүний байгаль орчинд үзүүлэх нөлөө гэх мэт хүний эрх зөрчигдөж байгаа маш өргөн хүрээтэй асуудлыг хөндөн ажилладаг. Хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн янз бүрийн хэлбэр, тухайлбал амьд явах, хоол хүнсээр хангагдах, эрүүл мэндийн боломжтой төвшний үйлчилгээ авах, шаардлага хангасан орон сууцаар хангагдах, нэр ба иргэншилтэй байх, боловсрол эзэмших, чөлөөтэй зорчих, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийн төлөө тэмцдэг. Мөн эмэгтэйчүүд, хүүхэд, уугуул иргэд, дүрвэгсэд болон дотооддоо шилжин суурьшсан хүмүүс зэрэг нийгмийн янз бүрийн бүлгийн эрх, тэрчлэн үндэстний болон хэлний, бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалан ажилладаг юм.



---

## **2. Хаа сайгүй хүний эрх**

Хүний эрхийг хамгаалагчид дэлхийн өнцөг булан бүрт, дотоодын хямрал мөргөлдөөнөөс болж хуваагдсан улс орнуудад ч, тогтвортой улс орнуудад ч, ардчилсан бус улсуудад ч, ардчилал хүчтэй хөгжсөн орнуудад ч, хөгжиж буй улсуудад ч, мөн өндөр хөгжилтэй орнуудад ч гэсэн идэвхитэй ажиллаж байдаг.<sup>2</sup> Тэд хүний эрхийг маш өргөн хүрээнд, түүний дотор ДОХ, ХДХВ, хөгжил, шилжилт хөдөлгөөн, бүтцийн зохицуулалтын бодлого болон улс төрийн шилжилтийн нөхцөлд ч хөхиүлэн дэмжих, хамгаалахыг эрмэлздэг.

## **3. Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын үйл ажиллагаа**

Хүний эрхийг хамгаалагчдын дийлэнх хэсэг орон нутгийн болон үндэсний төвшинд ажиллаж, өөрсдийн амьдарч байгаа газар, улс орондоо хүний эрхийг хүндэтгэн сахих үйлсэд дэмжлэг үзүүлж байдаг. Тийм ч учраас тэдний гол хамтран ажиллах хүмүүс нь орон нутгийн болон тухайн улсын хүний эрхийн асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллага байдаг. Хэдий тийм боловч, зарим хүний эрхийг хамгаалагчид бүсийн болон олон улсын төвшинд ажилладаг. Тухайлбал, тэд бүсийн болон дэлхийн хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдлыг хянаж, бүсийн буюу олон улсын хүний эрхийн байгууллагууд, түүний дотор НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн тусгай илтгэгчид болон НҮБ-ын бусад байгууллагуудад илтгэлээ хүргүүлдэг. Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаа улам бүр холимог шинжтэй болж байгаа бөгөөд тэд орон нутгийн ба үндэсний хэмжээнд хүний эрхийн асуудалд гол анхаарлаа хандуулахын хамт өөрийн улсын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлж чадах бүсийн болон олон улсын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

## **4. Хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлэл цуглуулах ба түгээх**

Хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн зөрчлийг эрэн сурвалжилж, мэдээлэл цуглуулдаг. Тухайлбал, олон нийтийн болон улс төр, шүүхийн томоохон албан тушаалтнуудын анхааралд гаргасан тайлангаа хүргэх,

---

<sup>2</sup> “Хүний эрхийг хамгаалагч” гэсэн нэр томъёо 1998 онд Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал батлагдсанаас хойш өргөнөөр хэрэглэгдэх болсон. Харин өмнө нь хүний эрхийн идэвхитэн, хүний эрхийн мэргэжилтэн, хүний эрхийн ажилтан, хүний эрхийг хянагч гэх мэт нэр томъёог хэрэглэдэг байсан. Хүний эрхийг хамгаалагч гэдэг нь илүү тохиромжтой, хэрэгтэй нэр томъёо гэж үзэж байна.

---

эрэн сурвалжлах ажил, хүний эрхийн зөрчлийн асуудалд зохих анхаарал хандуулах зэрэгт лоббидох стратегийг хэрэглэдэг. Ихэнхидээ иймэрхүү ажлыг хүний эрхийн байгууллагууд гүйцэтгэдэг бөгөөд өөрсдийн олсон баримтанд тулгуурлан тогтмол тайлан гаргаж байдаг. Гэхдээ мөн хүний эрхийн зөрчлийн тодорхой нэг асуудлаар хувь хүн мэдээлэл цуглуулж, тайлан гаргаж болно.

### ***5. Хүний эрхийн зөрчлөөс хохирогчдод дэмжлэг үзүүлэх***

Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны нэлээдгүй хэсгийг хүний эрхийн зөрчлийн хохирогчдыг дэмжин туслах явдал эзлэдэг. Хүний эрхийн зөрчлийн талаар эрэн сурвалжилж, тайлан гаргах нь тухайн зөрчлийг зогсоох<sup>3</sup>, дахин гарахаас урьдчилан сэргийлэх, хохирогчидод тухайн асуудлаар шүүхэд хандахад тус дөхөм болох зэрэг давуу талтай. Зарим хүний эрхийг хамгаалагчид хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөхөөс гадна хохирогчдыг шүүн таслах ажиллагаанд төлөөлдөг. Мөн хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хэвийн амьдралд эргэн ороход нь туслалцаа үзүүлдэг.

### ***6. Хариуцлагыг дээшлүүлэх, шийтгэл хүлээхгүй байхыг таслан зогсоох***

Маш олон хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх талаар ажилладаг. Энэ нь өргөн утгаараа, эрх баригчдыг лоббидох, хүний эрхийн талаархи олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ засгийн газар биелүүлэхэд илүү хүчин чармайлт тавихыг анхааруулан ажиллах зэрэг багтана. Бүр тодорхой авч үзэх юм бол хариуцлагыг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулна гэдэг нь хүний эрхийн хамгаалагчид аливаа хүний эрхийн зөрчлийн талаар олон нийтэд (жишээ нь, сонинд) буюу шүүхийн өмнө гэрчлэх явдлыг дэмждэг. Ийм маягаар, хүний эрхийн зөрчлийн тухайн тохиолдолд хохирогчдыг өмгөөлөн, шударга ёсыг сахиулахад хүний эрхийг хамгаалагчид хувь нэмрээ оруулдаг. Нэлээд тооны хүний эрхийг хамгаалагчид, өөрсдийн байгууллагаар дамжуулан хүний эрхийн зөрчил гаргагчдыг ял шийтгэлгүй үлдээхгүйн төлөө ажилладаг. Тэдгээр хүний эрхийг хамгаалагчид зөрчил үйлдэгчдийг мөрдөн шалгах төрийн чадавхийг бэхжүүлэх, тухайлбал прокурор, шүүх, цагдаагийн ажилтнуудад хүний сургалт явуулдаг.

<sup>3</sup> Хүний эрхийн олон улсын механизмын талаар дараахи гарын авлагуудаас тодруулна уу. Мэргэжлийн сургалтын цуврал ° 10 (Rev.1), 15, 16 (Rev.1), 17 , 27.

---

## ***7. Сайн засаглал ба засгийн газрын бодлогыг дэмжих***

Зарим хүний эрхийг хамгаалагчид засгийн газар бүхэлдээ хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд анхааран ажилладаг. Тэд жишээ нь, хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр засгийн газрын хийж буй ажлын талаар мэдээлэл түгээх, гарч буй ахиц дэвшилд хяналт тавьж байдаг. Зарим хүний эрхийг хамгаалагчид сайн засаглал, ардчиллыг дэмжих, авлига ба эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг таслан зогсоох, ард түмэнд хэрхэн саналаа өгөх, яагаад сонгуульд оролцох нь чухал гэдэг талаар сургалт явуулах зэрэгт гол анхаарлаа хандуулж ажилладаг.

## ***8. Хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулах***

Хүний эрхийг хамгаалагчид өөрсдийн байгууллагаар дамжуулан олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийг амьдралд хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Олон тооны төрийн бус байгууллага болон засгийн газар хоорондын байгууллагууд ядуу, эмзэг бүлгийнхнийг орон сууц, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, тэдэнд зориулан тогтвортой орлого бий болгох төслийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг. Тодруулбал, үндсэн ур чадварын сургалт явуулахаас гадна мэдээлэл авах нөхцлийг сайжруулах үүднээс компьютер гэх мэт техник хэрэгслээр хангадаг. Эдгээр байгууллагын гишүүдийг хүний эрхийг хамгаалагчид гэж тэр бүр тодорхойлдоггүй гэдгийг анхаарах хэрэгтэй бөгөөд тэд ч өөрсдийн ажлыг тодорхойлохдоо “хүний эрх” гэдэг нэр томъёоноос илүүтэйгээр “эрүүл мэнд”, “орон байр”, “хөгжил” гэх мэт өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийг тусгасан нэр томъёог хэрэглэдэг. Олон ТББ, НҮБ-ын байгууллагууд энэ ангилалд хамаарна. Тэдний ажил бусад хүний эрхийг хамгаалагчдын ажил үйлсийн нэгэн адил хүний эрхийн хэм хэмжээг хамгаалах, хэрэгжүүлэх, хүндэтгэхэд туйлын чухал бөгөөд тэдний үйл ажиллагааг Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд заасны дагуу хамгаалалт эдлэх шаардлагатай.

## ***9. Хүний эрхийн боловсрол ба сургалт***

Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны өөр нэг томоохон чиглэл бол хүний эрхийн боловсрол юм. Зарим тохиолдолд хүний эрхийн боловсролыг мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд, тодруулбал шүүгч, хууль, цагдаагийн ажилтан, цэргийн албан хаагч болон хүний

---

эрхийг хянагчид өөрсдийн үйл ажиллагаанд хүний эрхийн хэм хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт явуулах замаар олгодог. Харин зарим тохиолдолд хүний эрхийн боловсрол илүү өргөн хүрээг хамардаг бөгөөд хүний эрхийн тухай дунд ба дээд сургуульд заах, нийт хүн амд болон эмзэг бүлгийнхэнд зориулан хүний эрхийн хэм хэмжээний талаар мэдээлэл түгээх зэргээр хэрэгждэг.

Дүгнээд хэлбэл, мэдээлэл цуглуулж, түүнийгээ түгээх, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, хөдөлгөөнд оруулах зэрэг нь хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаандаа хамгийн түгээмэл хэрэглэдэг арга хэрэгсэл мөн. Гэхдээ өмнө дурдсанчлан, тэд мөн бусдыг зоригжуулах, сургалт явуулахын тулд мэдээллээр хангадаг. Хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон байр барих, хоол хүнсээр хангах, хөгжлийг бэхжүүлэх зэрэг материаллаг зүйлсээр хангах үйл ажиллагаанд мөн идэвхийлэн оролцдог. Тэд аж амьдралтай нь холбоотой шийдвэр гаргах үйл явцад ард түмний оролцоог нэмэгдүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхийн тулд ардчилсан өөрчлөлтийг дэмжин ажилладаг. Мөн тэд нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцлийг сайжруулах, нийгмийн болон улс төрийн хурцадмал байдлыг багасгах, дотооддоо ба олон улсын хэмжээнд энх тайвныг цогцлоох, хүний эрхийн тухай ойлголтыг үндэсний болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжих зэрэг үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байдаг.

## **Б. Хэн хүний эрхийг хамгаалагч болж чадах вэ?**

Хэнийг хүний эрхийг хамгаалагч гэж нэрлэх, эсвэл ямар хүн хүний эрхийг хамгаалагч болж чадах талаар тусгай тодорхойлолт одоогоор үгүй. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд (Хавсралт 1-ийг үзнэ үү) “хүний эрхийг хамгаалагч гэж хувь хүн хийгээд ард түмнүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчиж буй бүхий л хэлбэрийг үр дүнтэй арилгахын тулд хувь нэмэр оруулж байгаа хувь хүн, хэсэг бүлэг, нийгэмлэг холбоодыг хэлнэ” хэмээн заасан байдаг. (удиртгал хэсгийн 4-р зүйл). Энэхүү өргөн хүрээтэй тодорхойлолтын дагуу хүний эрхийг хамгаалагч гэдэг нь дэлхийн том хотуудад байрлах засгийн газар хоорондын байгууллагаас авахуулаад орон нутагтаа үйл ажиллагаа явуулдаг хувь хүмүүс зэрэг хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиглэлээр ажиллаж байгаа аливаа хувь хүн болон хэсэг бүлгийг хэлнэ.

---

Хамгаалагчид нас, хүйсийн хувьд ялгаатай, дэлхийн өнцөг булан бүрийг төлөөлсөн, төрөл бүрийн ажил мэргэжлийн хүмүүс байдаг. Ялангуяа, хүний эрхийг хамгаалагчид зөвхөн ТББ ба засгийн газар хоорондын байгууллагыг төлөөлдөггүй бөгөөд зарим тохиолдолд засгийн газрын албан тушаалтан, төрийн албан хаагч, хувийн хэвшлийнхэн ч байж болдог гэдгийг анхаарах нь чухал.

## **1. Мэргэжлийн үйл ажиллагаагаараа хүний эрхийг цалинтай болон сайн дураараа хамгаалах**

Хамгийн түгээмэл хүний эрхийг хамгаалагчид бол өдөр тутмын ажил үүрэг нь хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэж байдаг үндэсний хүний эрхийн байгууллагад ажилладаг хүний эрхийн хянагчид, хүний эрхийн омбудсмен болон хүний эрхийн хуульчид юм. Гэхдээ тухайн хүнийг хүний эрхийг хамгаалагч гэж тодорхойлоход түүний албан тушаал, эсвэл байгууллагынх нь нэр биш харин хийж буй ажлынх нь шинж чанар хамгийн чухал. Аливаа хүний хувьд хүний эрхийг хамгаалагч байхын тулд “хүний эрхийн идэвхитэн” гэж нэрлэгдэх буюу нэрэндээ “хүний эрх” гэж оруулсан байгууллагад ажиллах нь гол биш. НҮБ-ын олон ажилтан хэдийгээр тэдний өдөр тутмын үйл ажиллагаа “хөгжил” гэх мэт өөр нэр томъёогоор тодорхойлогддог ч хүний эрхийг хамгаалагчийн үүргийг гүйцэтгэж байдаг юм. Түүний нэгэн адил, дэлхий даяар хүмүүнлэгийн асуудлаар ажиллаж байгаа үндэсний болон олон улсын ТББ-ын ажилтнуудыг ч мөн хүний эрхийг хамгаалагч гэж хэлж болно. Хүн амд ДОХ-ын сургалт явуулдаг, уугуул хүн амын эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг хүмүүс, байгаль орчны идэвхитнүүд, хөгжлийн төлөөх сайн дурынхан зэрэг хүмүүс хүний эрхийг хамгаалагчдын үйлсэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг. Олон хүн мэргэжлийн хувьд хүний эрхийг хамгаалагчаар ажиллаж, түүнийхээ төлөө цалин хөлс авдаг. Гэхдээ бусад олон хүн мэргэжлийн хувьд хүний эрхийг хамгаалагчаар сайн дураараа ажилладаг бөгөөд түүнийхээ төлөө цалин хөлс авдаггүй. Ихэвчилэн хүний эрхийн байгууллагууд маш хязгаарлагдмал санхүүжилттэй байдаг тул эдгээр сайн дурынхны хийж буй ажил үнэлж баршгүй тустай юм.

Мэргэжлийн олон үйл ажиллагаа хүний эрхийн асуудлыг байнга хөнддөггүй хэдий ч зарим тохиолдолд хүний эрхийн асуудалтай ямар нэг сэжмээр холбогддог. Жишээ нь, худалдааны асуудлаар мэргэшсэн хуульчид тэр бүр хүний эрхтэй холбоотой асуудлаар ажилладаггүй учир тэднийг хүний эрхийг хамгаалагчид гэж шууд тодорхойлох боломжгүй.

---

Гэсэн хэдий ч, тэд зарим тохиолдолд хэрэг маргаан дээр ажиллахдаа хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулж байдаг. Түүний нэгэн адил, үйлдвэрчний эвлэлийн удирдагчдын авч хэрэгжүүлж буй олон тооны үйл ажиллагаа хүний эрхтэй холбоогүй байдаг ч тэд тухайлан хөдөлмөрчдийн хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр ажиллаж байгаа тохиолдолд тэднийг хүний эрхийг хамгаалагчид гэж тодорхойлж болно. Мөн түүнчлэн, сэтгүүлчид мэдээлэл цуглуулах түүнийгээ хэвлэл, радио, телевизээр дамжуулан олон нийтэд хүргэх өргөн эрх мэдэлтэй байдаг. Ерөнхий үүрэг ролийн хувьд сэтгүүлчид хүний эрхийг хамгаалагч байдаггүй. Гэвч олон сэтгүүлч жишээ нь хүний эрхийн зөрчлийн талаар сурвалжилж, үзэж харсан зүйлээ гэрчлэн мэдээлж байдгаараа хүний эрхийг хамгаалагчийн үүргийг гүйцэтгэж байдаг билээ. Шавь нартаа хүний эрхийн үндсэн зарчмын талаар зааж сургаж байдаг багш нар ч мөн нэгэн адил энэ үүргийг гүйцэтгэдэг. Хүний эрхийн зөрчлийн улмаас хохирсон хүмүүсийг эмчлэж, асарч байгаа эмч, эмнэлгийн ажилчдыг хүний эрхийг хамгаалагч гэж хэлж болох бөгөөд эмч нар өргөсөн тангарагаараа онцгой үүрэг хүлээдэг билээ.

Шударга ёсыг сахиулахад хувь нэмрээ оруулдаг шүүгч, цагдаа, хуульч болон бусад хүмүүс олонхи тохиолдолд онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд засгийн газар буюу бусад эрх мэдэлтнүүд, тухайлбал зохион байгуулалттай гэмт хэргийн удирдагчдад тааламжтай шийдвэр гаргуулахын тулд нэлээдгүй дарамт шахалтийг тэдэнд үзүүлэх нь бий. Шүүхийн үйл ажиллагаан дахь эдгээр оролцогчид шударга, аль нэг талыг бариагүй шүүхийн шийдвэр гаргахын тулд онцгой хүчин чармайлт тавьж, ингэснээрээ хохирогчдын хүний эрхийг баталгаажуулж байдаг тул тэднийг хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хийж байна гэж дүгнэж болно. Үүнтэй төстэй “онцгой хүчин чармайлт”-ыг хүний эрхтэй шууд холбоотой бус ажил мэргэжлийн олон төрлөөс олж болно. Тодруулбал, хүмүүс зарим үед өөрсдийн ажлыг хүний эрхийг дэмжсэн арга замаар хийж гүйцэтгэдэг. Жишээ нь, зарим архитектор барилгын зураг төсөл хийхдээ барилга дээр ажиллах хүмүүсийн зохих (түр зуурын) орон байраар хангагдах эрх, хэрэв тухайн барилга хүүхдэд зориулагдсан бол түүний төслийн талаар хүүхдүүдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх зэргийг харгалзан үздэг.

---

## 2. Мэргэжлийн бус хүрээнд хүний эрхийг хамгаалах

Олон хүн өөрсдийн мэргэжил, ажил хөдөлмөрийнхөө хүрээнээс гадуур хүний эрхийн хамгаалагчаар ажилладаг. Жишээ нь, хорих газрууд дахь эрүүдэн шүүлтийг зогсоохын төлөөх кампанит ажилд бусдыгаа зохион байгуулж байгаа оюутныг хүний эрхийг хамгаалагч гэж үзэж болно. Үйлдвэрийн хог хаягдлаас болж орон нутгийнх нь байгаль орчин сүйдэж байгаагийн эсрэг нутаг нэгтнүүдээ уриалан, эсэргүүцэл зохион байгуулж байгаа хөдөөгийн оршин суугчийг ч хүний эрхийг хамгаалагч гэж нэрлэж болно. Засгийн газарт бугшсан авлигын эсрэг сөрөн зогсож байгаа улс төрч нь сайн засаглал болон тэрхүү авлигын заналхийлж байдаг зарим хүний эрхийг хамгаалж, хөхиүлэн дэмжиж байгаагаараа хүний эрхийг хамгаалагч болно. Хүний эрхийг зөрчигчдийн эсрэг шүүхэд гэрчийн мэдүүлэг өгч байгаа, олон улсын хүний эрхийн байгууллага буюу орон нутгийнхаа шүүхэд хүний эрхийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхэд нь туслаж, мэдээлэл өгч байгаа хүмүүсийг ч энэхүү үйл ажиллагааных нь хүрээнд хүний эрхийг хамгаалагчид гэж үзэж болно.

Дэлхийн бүх хүмүүс өөрсдийн нөхцөл байдалд тохируулан, өөрсдийн арга барилаар хүний эрхийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж байдаг. Зарим хүний эрхийг хамгаалагчид олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг хэдий ч хүний эрхийг хамгаалагчдын дийлэнхи хэсэг бусдад танигдалгүй үлддэг. Орон нутгийн албан тушаалтан ч бай, хууль сахиулагч цагдаагийн ажилтан ч бай, эсвэл шударга бус явдлыг олонд таниулж байгаа урлагийн хүн ч бай бүгдээрээ хүний эрхийг урагшлуулан хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Хамгийн гол нь тэдгээр хүмүүс хүний эрхийг дэмжсэн ямар үйл ажиллагаа явуулж байгаа, зарим тохиолдолд тэд энэ талаар “онцгой чармайлт” гаргасан эсэхийг анхаарах учиртай. Мэдээжийн хэрэг, хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны өргөн цар хүрээг бүгдийг жагсаан бичих боломжгүй юм. Гэхдээ хүний эрхийг хамгаалагчдад байдаг түгээмэл чанар бол бусдад туслахын төлөө, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө зүрх сэтгэлээ зориулж, эрх тэгш байдлын төлөө, ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг тууштай зогсож, дийлэнхи тохиолдолд асар их зүрх зоригтой байх явдал билээ.

---

## **В. Хүний эрхийг хамгаалагчдад тавигдах наад захын шаардлага гэж бий юу?**

Хүний эрхийг хамгаалагч болохын тулд ямар ч “мэргэжил, ур чадвар” шаардагдахгүй бөгөөд дээр өгүүлсэнчлэн Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд хэрэв бид өөрсдөө хүсвэл бүгдээрээ хүний эрхийг хамгаалагч байж чадна гэдгийг тодорхой заасан байдаг. Гэсэн хэдий ч, хүний эрхийг хамгаалагчид шаардагдах “хэм хэмжээ” гэдэг маш төвөгтэй асуудал бөгөөд Тунхаглалд хүний эрхийг хамгаалагчид эрх эдлэхээс гадна үүрэг хүлээх ёстойг тодорхой заасан. Энэхүү гарын авлага доорхи 3 асуудалд анхаарлыг тань хандуулж байна:

### ***Хүний эрхийн түгээмэл шинжийг хүлээн зөвшөөрөх нь***

Хүний эрхийг хамгаалагчид Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан эрхийг бүх нийтээр хэрэгжүүлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой<sup>4</sup>. Хүний эрхийн зарим төрлийг үгүйсгэдэг ямар ч хүн хэдий бусдыг өмгөөлөн ажилладаг байлаа ч өөрийгөө хүний эрхийг хамгаалагч гэж үзэж болохгүй. Жишээ нь, эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалаад, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг үгүйсгэх явдлыг хүлээн зөвшөөрч үл болно.

### ***Хэн нь зөв, хэн нь буруу байх тийм чухал гэж үү?***

Хоёр дахь чухал асуудал бол гаргаж тавьсан нотолгоо баримтны хүчин төгөлдөр байгаа эсэх юм. Жинхэнэ хүний эрхийг хамгаалагч байхын тулд гаргаж тавьж буй баримт нотолгоо тань заавал зөв байх албагүй. Хамгийн чухал нь тухайн хүн хүний эрхийг хамгаалж байна уу үгүй юу гэдэгт оршино. Жишээ нь, хэсэг хүний эрхийг хамгаалагчид хөдөөгийн хүн амын хэдэн үеэрээ амьдарч, үр шимийг нь хүртэж байсан газраа өмчлөх эрхийн төлөө тэмцэж байлаа гэж бодъё. Тэгвэл тэд тухайн газрыг өмчлөхийг санаархаж байгаа хувийн хэвшлийнхний ашиг сонирхлын эсрэг эсэргүүцэл өрнүүлж болно. Тэд хэн чухам уг газрыг өмчлөх ёстой талаар зөв ч эсвэл буруу ч байр суурь баримталж байж болно. Гэхдээ, хууль зүйн хувьд зөв байх эсэх нь тэднийг жинхэнэ хүний эрхийг хамгаалагч эсэхийг тодорхойлоход хамаатай бус. Хамгийн гол нь тэдний хөндөж буй асуудал хүний эрхийн хүрээнд хамаарч байна уу үгүй гэдэгт байдаг. Энэ бол туйлын чухал асуудал. Учир нь олон оронд хүний эрхийг хамгаалагчдыг аливаа асуудлын зөвхөн нэг талыг барьж байгаа мэт хардаг учраас засгийн газар, тэр ч байтугай олон нийт тэднийг буруутгаж, “жинхэнэ” хүний эрхийг хамгаалагч биш гэж

---

<sup>4</sup>НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны 217 А (III)-р тогтоолоор батлагдсан. Мэргэжлийн сургалтын цуврал ° 2, Олон улсын хүний эрхийн билл (Rev.1)-ийг үз.



---

хэлдэг. Түүний нэгэн адил улс төрийн хоригдол, эсвэл зэвсэглэсэн сөрөг хүчний хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа хүний эрхийг хамгаалагчдыг засгийн эрх баригчид зөвхөн тэдгээр хүмүүсийн эрхийг хамгаалсных нь төлөө тийм нам, бүлгийг дэмжигч хэмээн тодорхойлох нь элбэг байдаг. Энэ бол буруу юм. Хүний эрхийг хамгаалагчдыг ямар эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаагаар нь болон, тийм үйл ажиллагаа явуулах өөрсдийнх нь эрхийн хүрээнд тодорхойлж, хүлээн зөвшөөрөх ёстой.

***Тайван замаар үйл ажиллагаагаа явуулах***

Эцэст нь тэмдэглэхэд, хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаа Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд заасны дагуу тайван замаар явагдах ёстой.



---

## II. ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ЭСРЭГ ГАРДАГ ЗӨРЧИЛ, ТЭДЭНД ТОХИОЛДДОГ БУСАД БЭРХШЭЭЛ

Хүний эрхтэй холбоотой ажил болгон хүний эрхийг хамгаалагчдыг эрсдэлд учруулдаггүй бөгөөд зарим улсад хүний эрхийг хамгаалагчид ерөнхийдөө сайн хамгаалагдсан байдаг. Гэвч хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлддэг халдлагын ноцтой байдал, хэмжээ, далайц зэрэг нь Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалыг батлан гаргаж, Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаархи НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгчийн орон тоог бий болгох үндэсэн хүчин зүйлийн нэг болсон билээ. Тусгай төлөөлөгч бүх улс оронд, түүний дотор ардчиллыг шинээр тогтоосон болон ардчиллын удаан жилийн түүхтэй орнуудад ч хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдалд сэтгэл зовниж буйгаа илэрхийлсэн билээ. Тэрээр доорхи орнуудыг онцгой анхааран авч үзсэн байна. Үүнд:

(а) дотоодын зэвсэгт мөргөлдөөн буюу иргэний ноцтой түгшүүртэй байдал бий болсон улсууд;

(б) Хүний эрхийг хамгаалах эрх зүйн болон бүтцийн хамгаалалт бүрэн бий болж чадаагүй буюу тийм хамгаалалт огтоос байхгүй орнууд.

Дэлхийн бүс нутаг болгонд тоо томшгүй хүний эрхийг хамгаалагчдын эрх зөрчигдсөөр байна. Тэднийг цаазаар аваачих, эрүүдэн шүүх, зодож нүдэх, шүүхийн шийдвэргүйгээр баривчилж хорих, амь насанд нь заналхийлэх, нэр төрийг нь гутаан доромжлох зэрэг үйлдлийн золиос болгож, чөлөөтэй зорчих, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нь хязгаарлаж байна. Хүний эрхийг хамгаалагчид худал мэдүүлэг, шударга бус шүүх ажиллагаа ба ял шийтгэлийн золиос болж байдаг. Түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдад дарамт, шахалт үзүүлэх зорилгоор тэдний гэр бүлийг хүний эрхийн зөрчлийн бай болгодог. Зарим хүний эрхийг хамгаалагчид хамгаалж буй эрхийнхээ онцлогоос шалтгаалж илүү их эрсдэлд өртдөг. Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд зарим үед хүйсэд тулгуурласан эрсдэлтэй учирдаг тул онцгой анхаарал шаарддаг. Ихэнхи тохиолдолд, хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлж байгаа гэмт хэрэг нь дотоодын ба олон улсын хуулийг зөрчиж байдаг. Харин зарим оронд олон улсын эрх зүйтэй харшилсан дотоодын хууль тогтоомжийг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг ашигладаг.

---

## А. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зөрчлийн жишээ

Хүний эрхийг хамгаалагчид ажил үүргээ гүйцэтгэж явахдаа тулгардаг хүний эрхийн зарим зөрчил, саад бэрхшээлийг доор дурдлаа. Эдгээр гэмт үйлдэл нь зарим үед цорын ганц удаа тохиолдолддог хэдий ч хүний эрхийг хамгаалагчид болон тэдний гэр бүлд сар жилээр үргэлжилсэн хүнд цохилт болдог. Жишээ нь, амь насанд заналхийлсэн тохиолдолд хүний эрхийг хамгаалагчид өөрийн болон ойр дотны хүмүүсийнхээ өдөр тутмын амьдралын хэв маягийг тэр чигт нь өөрчлөх, эсвэл бүр гадаадад түр хугацаагаар орогнол эрэхийн тулд тухайн улсыг орхин явахаас аргагүйд хүрдэг юм. Хүний эрхийг хамгаалагч олон хүн хүний эрхийн үйл ажиллагаатайгаа шууд холбоотойгоор **амь насаа алддаг**. Тэднийг үл таних хүмүүс эсвэл зарим тохиолдолд хүчний байгууллагынхан хүчээр авч явдаг бөгөөд хожим нь тэдний цогцос олдох буюу тэр чигээрээ сураггүй алга болдог. Амь насанд халдах оролдлогоос болж хүний эрхийг хамгаалагчид хүнд шархдан, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх буюу мэс засал хийлгэхээс аргагүй болох нь бий.

Дэлхийн зарим бүс нутагт хүний эрхийг хамгаалагчдын ажлыг зогсоох, айлган сүрдүүлэх зорилгоор амь насанд нь заналхийлэх явдлыг түгээмэл хэрэглэдэг. Ийм заналхийлэл нь ихэнхидээ нэр усгүй, утсаар буюу захиагаар ирдэг. Зарим тохиолдолд, хүний эрхийг хамгаалагчдыг өөрсдийнх нь таниж мэддэг боловч цагдаагийн байгууллага мөрдөн шалгаагүй, ял шийтгэл аваагүй хүмүүс заналхийлэх нь бий. Аллага болон **амь насанд заналхийлэх** явдлыг цагдаа, шүүхийн байгууллага үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй байх нь эдгээр зөрчлийг улам гааруулж, шийтгүүлэхгүй байж болдог юм байна гэсэн уур амьсгалыг бий болгодог. Заримдаа, хүний эрхийг хамгаалагчдыг урт буюу богино хугацаагаар **барьцаалах**, барьцаанд байлгах хугацаандаа **зодож нүдэх** явдал тохиолддог. Цэрэг, цагдаа, хүчний байгууллагын ажилтнууд хүний эрхийг хамгаалагчдаас мэдүүлэг авах, хүчний байгууллагын үйлдсэн хүний эрхийн зөрчлийн тухай мэдүүлгээс нь татгалзуулахын тулд тэднийг эрүүдэн шүүхийг оролдох, зодож нүдэх тохиолдол олонтаа гардаг.

Хүний эрхийг хамгаалагчдыг **хууль бусаар баривчлан хорих** нь түгээмэл тохиолддог бөгөөд дийлэнхидээ ямар ч баривчлах зөвшөөрөл, албан ёсны шийдвэргүйгээр гүйцэтгэдэг. Хэргийг хяналгүйгээр урьдчилан саатуулах хугацаа зарим үед асар урт байдаг бөгөөд маш

---

муу нөхцөлд хорьдог. Ялангуяа, хүний эрхийг хамгаалагчид хоригдож байх үедээ зодуулах, доромжлуулах буюу эрүү шүүлтэд илүүтэй өртдөг. Зарим тохиолдолд, хүний эрхийг хамгаалагчдын эсрэг **эрүүгийн болон бусад хэрэг** үүсгэж, **мөрдөн байцааж, ял оноодог**. Тайван жагсаал цуглаан, цагдаагийн зүй бус харьцааны талаар албан ёсоор гомдол гаргах, уугуул иргэдийн эрх ашгийг хамгаалах цуглаанд оролцох, хүний эрхийн зөрчлийн золиос бологсдын дурсгалыг хүндэтгэсэн самбар барьж жагсах зэргийн алиныг нь ч хээл хахууль авсан, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан буюу танхайрсан зэрэг шалтгаанаар буруутгаж мөрдөн шалгадаг. Ийм төрлийн хэрэгт шүүхээс удаан хугацаагаар хорих ял, сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлүүлэх, “хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх” зэрэг ял оноодог байна.

Хүний эрхийг хамгаалагчдыг **сүрдүүлэх** явдал түгээмэл тохиолддог бөгөөд ихэнхидээ мэдэгдэлгүй өнгөрдөг. Засгийн эрх мэдэлтнүүд ингэж сүрдүүлэх нь нийтлэг бөгөөд маш өргөн хүрээний нөхцөл байдлыг хамарна. Хүний эрхийг хамгаалагчдын араас тагнаж, утасны шугамыг нь таслах буюу нууцаар чагнадаг. Мөн гадаадад болох хүний эрхийн чуулганд оролцуулахгүй байхын тулд иргэний болон аялалын бичиг баримтыг нь хурааж авдаг. Хүний эрхийн хуульчдыг мэргэжлээрээ ажиллах эрхийг цуцлахаар заналхийлэх буюу тэднийг мөрдөн шалгадаг. Хүний эрхийг хамгаалагчид засаг захиргааны дарамт шахалтад өртдөг бөгөөд жишээ нь, тун захиргааны өчүүхэн зөрчил гаргасны төлөө асар их торгууль төлөх, эсвэл ямар ч тодорхой шалтгаангүйгээр, удаан хугацааны турш засаг захиргааны байгууллагад ахин, дахин тайлангаа гаргаж өгөх хэрэгтэй болдог. Шүүгчдийг хариуцан ажиллаж буй хэргээс нь өөрчилж, нэг тойргоос нөгөө рүү шилжүүлдэг бөгөөд гэр бүлтэйгээ хамт улсынхаа нэг захаас нөгөө рүү нүүхээс аргагүйд хүргэдэг байна.

Түүнчилэн, хүний эрхийг хамгаалагчид төрийн хяналтад байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өрнөсөн **нэр төрийг нь гутаах, гүтгэлгийн** кампанит ажлын золиос болох нь элбэг. Хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл тараадаг бие даасан ТББ болон сэтгүүлчдийн нэр төрийг гутаах зорилгоор элдэв зүйлийг санаанаасаа зохиодог. Хүний эрхийг хамгаалагчид болон тэдний хийж буй ажлыг олон нийтэд буруугаар сурталчилж, тэднийг террорист, босогчид, засгийн газрыг унагаахыг санаархагчид, эсвэл улс төрийн сөрөг хүчний төлөө ажиллаж байгаа хүмүүс гэж ойлгуулахыг хичээдэг. Засгийн эрх мэдэлтнүүд болон төрийн

---

хэвлэл мэдээлэл хүний эрхийг хамгаалагчдыг тэдний эрх ашгийг нь хамгаалахаар тэмцэж байгаа хүмүүстэй нь адилгаж үздэг. Жишээ нь, зэвсэглэсэн сөрөг бүлгийнхний эрхийг хамгаалж байгаа хүний эрхийг хамгаалагчдыг өөрсдөө тэдгээр бүлэгт харьяалагддаг хэмээн сурталчилдаг.

**“Аюулгүй байдлын”** арга хэмжээ гэгддэг аливаа **бодлого, хууль дүрэм, үйл явцыг** заримдаа хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хязгаарлах, тэр ч бүү хэл хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хэрэглэдэг. Аюулгүй байдлыг хангах нэрийн дор хүний эрхийг хамгаалагчдыг оршин суугаа газраа орхин явахыг хориглох, цагдаа болон аюулгүй байдлын бусад ажилтнууд хүний эрхийг хамгаалагчдыг албан өрөөндөө дуудан авчирч, хүний эрхийн үйл ажиллагааг нь зогсооно гэж айлган сүрдүүлдэг. Хүний эрхийг хамгаалагчдыг аюулгүй байдлын талаархи маш бүрхэг заалттай хуулийн дагуу мөрдөн шалгаж, буруутай хэмээн удаан хугацаагаар хорих ял сонсгодог.

Хувь хүмүүст чиглэсэн дээрх зөрчлүүдээс гадна, зарим оронд **хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаагаа явуулдаг орчныг хязгаарлах** стратегийг нэлээд хэрэглэдэг. Хүний эрхийн байгууллагуудыг өчүүхэн зүйлээр шалтаглан үйл ажиллагааг нь хаах, санхүүжилтийн эх үүсвэрийг нь таслах буюу зүй бусаар хязгаарлах, хүний эрхийн чиглэлээр ажиллах шинэ байгууллагыг бүртгэх явдлыг зориудаар удаашруулах зэргийг дурдаж болно. Засгийн эрх баригчид хүний эрхийг хамгаалагчдын хурал чуулганд саад тотгор учруулж, тэднийг хүний эрхийн байдлыг судлахаар өөр газар руу явахад саад тавьдаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эвэлэдэн нэгдэх болон чөлөөтэй зорчих зэрэг эрхийг **хууль ёсоор эдлүүлэхээр баталгаажуулсан хууль тогтоомж** тухайлбал ТББ-ын үйл ажиллагааг бүртгэх, зохицуулах, эсвэл хүний эрхийн үйл ажиллагаанд зориулан гадаадаас санхүүжилт авахыг хориглосон буюу хязгаарласан хуулийг хүний эрхийг хамгаалагчдыг сүрдүүлэх, ажилд нь саад тотгор учруулах зорилгоор ашигладаг. Хүний эрхийг хамгаалагчдын ажилд саад болохыг зорьсон зарим оролдлого тэдний байрлаж буй газар, ажлын багаж хэрэгсэл рүү чиглэдэг. Тэдний **ажлын газар** буюу **орон гэрийг довтлох, эд юмсыг нь хулгайлах, зөвшөөрөлгүйгээр нэгжлэг** хийдэг. Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаагаа явуулдаг газрыг эрх баригчдаас хаах буюу банкны дансаар гүйлгээ хийхийг нь

---

зогсоодог. Тоног төхөөрөмж, бичиг баримт, түүний дотор компьютер, албан бичиг, фото зураг, дискүүдийг нь хулгайлах буюу хурааж авдаг. Интернет ба олон улсын цахим шуудангийн холболтыг хязгаарлах буюу хяналт тавьдаг.

Дээр дурдсан хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдэгдэж буй бүх зөрчил арилахгүй байгаа нь олон оронд оршсоор байгаа эдгээр зөрчлийг үйлдсэн хүмүүс **ял шийтгэлгүй** үлдэх боломж байдагтай холбоотой.

## **Б. Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн нөхцөл байдал**

Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд дээр А хэсэгт дурдсан бүхий л бэрхшээлтэй тулгарч байдаг. Тэдний өвөрмөц нөхцөл байдал, үүрэг роль тэдэнд тулгарч буй дарамт шахалт, бусад бэрхшээл хэрхэн нөлөөлж байгаад онцгой анхааралтай хандах хэрэгтэй гэдгийг сануулдаг. Эмэгтэй ч бай эрэгтэй ч бай хүний эрхийг хамгаалагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд нь хамгаалалт, дэмжлэг туслалцаа үзүүлэх, мөн эдгээр эмэгтэйг хүний эрхийг хамгаалагч хэмээн бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөх зэрэг нь амин чухал зүйл мөн.

Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчид эрэгтэй хамгаалагчдад тохиолддог оос ялгаатай дарамт шахалтад өртдөг тухай цөөн жишээг доор дурдсан бөгөөд чухам ийм учраас тэдэнд онцгой хамгаалалт шаардагдаж байгаа юм.

Доор В хэсэгт дурдсанчлан, төр бол хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зөрчил өдүүлдэг хамгийн гол субъект байдаг. Гэхдээ эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын хувьд тэдний эрхийг ихэвчилэн хүний эрхийн үйл ажиллагаанд дургүйцэж эсэргүүцдэг нутгийнх нь хүмүүс зөрчдөг бөгөөд тухайн нутгийн зарим нэр нөлөө бүхий хүмүүс эмэгтэйчүүдийн үүрэг ролийн талаархи уламжлалт ойлголтод харшилсан зүйл гэж үздэг. Засаг захиргааны байгууллага ихэнхидээ эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг заналхийлж байгаа нийгмийн хүчний эсрэг зохих хамгаалалт үзүүлж чаддаггүй.

Дэлхийн бөмбөрцгийн ихэнхи хэсэгт эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэг ролийг нийгмийн соёлын салшгүй хэсэг хэмээн үздэг билээ. Энэ нь ялангуяа эмэгтэй хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийг зөрчиж

---

байгаа зан заншил, соёлын хүчин зүйлийн талаар асуудал дэвшүүлэх буюу эсэргүүцэхэд маш их хүндрэл учруулдаг. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх нь үүний тод жишээ бөгөөд мэдээж өөр иймэрхүү жишээ олон. Түүнчлэн, олон эмэгтэйчүүд нутаг ус, гэр бүлийнхнийхээ нүүр царай гэж тооцогддог. Хэрэв нэг хүний эрхийг хамгаалагч эмэгтэй өөрийн ажлын улмаас хүчиндүүлсэн бол гэр бүлийнхэн нь түүнийг зөвхөн гэр бүлдээ төдийгүй нутаг усныхныгаа шившигт хутгалаа гэж үздэг. Хүний эрхийг хамгаалагч гэдгээрээ уг эмэгтэй хүчингийн гэмт хэргээс үүдсэн гэмтэл, шаналлаас гадна хүний эрхийн ажил хийснээрээ ойр тойрныхондоо ичгүүр авчирсан гэдэг зэмлэлийг давхар үүрэх болдог. Хүчингийн хэрэг эсвэл элдэв дайралт тохиолдоогүй байсан ч хүний эрхийг хамгаалагч болохыг сонгосон эмэгтэй гэр бүл, нутаг орныхоо нэр төр, соёлыг бусниулж байна хэмээн үздэг хүмүүсын уур хилэнтэй байнга тулгардаг. Хүний эрхийн ажлыг нь таслан зогсоохыг шаардсан дарамт шахалт маш хүчтэй байдаг. Өдөр тутам бага насны хүүхдээ болон өндөр настай эцэг эхээ асрах үүрэг хүлээсэн эмэгтэй хүний эрхийн ажлаа үргэлжүүлэн хийхэд маш хэцүү гэдэг нь ойлгомжтой. Учир нь тэрээр баривчлагдах буюу хоригдоход хүрвэл гэр бүлийнхээ өмнө хүлээсэн энэхүү үүргээ биелүүлж чадахгүйд хүрнэ гэдгээ мэднэ.

Хэдийгээр манай дэлхий дээр эрчүүд асрамжиндаа байгаа хүмүүсийг анхаарч халамжлах үүргийг хуваалцах нь нэмэгдсэн ч гэсэн энэ асуудал хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн сэтгэлийг зовоосон хэвээр байгаа юм. Гэхдээ нөгөө талаар, эмэгтэйчүүд энэхүү үүрэг ролио хүний эрхийг хамгаалагчийн ажлаа бэхжүүлэхэд ашиглах тохиолдол байдаг. Тухайлбал, сураггүй алга бологсдын ээжүүд хүний эрхийн байгууллага үндэслэн байгуулсан жишээ бий. Тэд хүний эрхийн зөрчлийн золиос бологсдын ээжүүд гэдэг утгаараа өөрсдийн үйл ажиллагаанд маш хүчтэй дэмжлэг олж чадсан юм.

Хүний эрхийн асуудлын ээдрээтэй байдал заримдаа эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад онцгой дарамт шахалт үзүүлж байдаг. Олон соёлын хүрээнд эмэгтэйчүүдийг эрчүүдээс доогуур үздэг явдал тэднийг хүний эрхийн зөрчилтэй холбогдуулан эрчүүдэд нээлттэй асуулга тавих үйл ажиллагаанд саад тотгор учруулдаг юм. Түүний нэгэн адил, зарим нэг шашны сургаалын тайлбарыг хууль дүрмийг тогтоохдоо хэрэглэдэг бөгөөд тэр нь хүний эрхэд маш ихээр нөлөөлдөг. Тиймэрхүү хууль дүрэм, тэдгээрийн хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөний талаар эмэгтэй хүний эрхийг хамгаалагчид асуудал дэвшүүлэхэд эмэгтэй хүн

---

болохоор нь тийм шашны сургаалыг тайлбарлах эрх байхгүй гэдгээр хаалт тавьдаг. Өөрөөр хэлбэл, эдгээр эмэгтэй хүний эрхийг хамгаалагчид эрэгтэйчүүдтэй ижил төвшинд харилцах эрхгүй байдаг бөгөөд үүнийг ч тэдний эсрэг хамгийн түрүүнд ашигладаг билээ. Дахин хэлэхэд, эдгээр эмэгтэйчүүд нутгийнхаа хүмүүсийн дайсагналыг тэвчин амьдрах хэрэгтэй болдог. Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад тохиолддог бэрхшээлийг эрэгтэй хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээлээс илүү өргөн хүрээнд ойлгож, дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

## **В. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зөрчил өдүүлэгчид**

Төрийн удирдах байгууллага хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үүрэг хариуцлага хүлээх ёстой хэдий ч харин тэдний эсрэг хамгийн түгээмэл зөрчил өдүүлэгч байдаг. Хэдий тийм боловч, янз бүрийн “төрийн бус” оролцогчид хүний эрхийг хамгаалагчдын эсрэг мөн зөрчил үйлдэж байдаг тул тэдгээрийн үүрэг хариуцлагыг мэдэж байх нь чухал.

### **1. Төрийн удирдах байгууллага**

Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зөрчил гаргасан төрийн бүх удирдах байгууллагыг энд жагсаан бичих боломжгүй билээ. Гэхдээ зарим нэг жишээг дурдах нь чухал бөгөөд ихэнхи тохилдолд аль нэг улсын засаг захиргаа хүний эрхийн зөрчлийг өдүүлэгч байхад, нөгөө улсын удирдлага тухайн үйлдлийг урьдчилан сэргийлэх буюу хариу арга хэмжээ аваагүй гэдгээрээ мөн хамтран үйлдэгч болдог гэдгийг анхаарах ёстой. Энд төрийн удирдах байгууллага гэдэгт засаг захиргааны болон улс төрийн төвшний олон янзын эрх барих байгууллагууд, мөн түүнчлэн орон нутгийн болон үндэсний хэмжээний удирдах байгууллагуудыг хамруулан ойлгох ёстой.

Цагдаа, хүчний байгууллага нь хууль бус баривчилгаа, нэгжлэг, бие махбодын хүчирхийлэл зэргийг үйлддэгээрээ олны нүдэнд хамгийн ил байдаг хүний эрхийн зөрчил үйлдэгчид юм. Гэхдээ төрийн бусад байгууллага ч үүнд мөн оролцдог. Тухайлбал, орон нутгийн удирдлагаас гаргасан баривчлах зөвшөөрлийн дагуу олон улсын хэм хэмжээг зөрчсөн баривчилгаа явагдаж, улмаар тухайн хүнийг мөрдөн байцааж, ял тулгасан тохиолдолд цагдаа, хууль, шүүхийн байгууллагын



---

ажилтнууд бүгд уг хүний эрхийг хамгаалагчийн эрхийг хамтран зөрчсөн хэрэг болно.

Хүний эрхийг хамгаалагчдыг ТББ-аа бүртгүүлэх буюу цугларч уулзахад нь саад болох үүднээс хууль буюу захиргааны журмыг буруугаар хэрэглэсэн тохиолдолд тийм шийдвэр гаргасан иргэний удирдах байгууллага гол хариуцлагыг хүлээнэ. Олон оронд төрийн захиргааны байгууллага нь хүний эрхийг хамгаалагчдыг зориудаар захиргааны “хууль бус үйлдэл” хийхэд түлхээд, түүн дээрээ үндэслэн тэднийг баривчилж хорин, ял тулгадаг. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зарим хэрэг тухайлбал нэр хаяггүйгээр амь насанд заналхийлэх зэргийн үйлдэгчийг тодорхойлоход төвөгтэй байдаг. Энэ тохиолдолд, холбогдох төрийн захиргааны байгууллага тухайн хэргийг мөрдөн шалгах, шаардлагатай бол хохирогчийг түр зуурын хамгаалалтад авах, буруутай этгээдүүдийг мөрдөн шалгах үүрэг хүлээнэ. Хэрэв төрийн захиргааны байгууллага ийм арга хэмжээ авахгүй бол хүлээсэн үүргээ зөрчиж байгаа хэрэг мөн. Амьдрал дээр зарим орны цагдаагийн байгууллага хүний эрхийг хамгаалагчид руу халдсан тухай өргөдлийн дагуу арга хэмжээ авахаас татгалзах, тэр ч бүү хэл өргөдлийг нь бүртгэж авахгүй байх, шүүхийн байгууллага нь тухайн хэргийг хэлэлцэхэд хайхрамжгүй хандах тохиолдол элбэг байдаг. Ийнхүү эрх баригчдын арга хэмжээ авахгүй байх нь хүний эрхийн зөрчлийг үргэлжлүүлэх, дахин давтагдах, улам ноцтой болгож, амь насанд олон дахин заналхийлсээр эцэст нь хүний эрхийг хамгаалагчийн амь насыг бусниулахад хүргэдэг.

## 2. Төрийн бус оролцогчид

“Төрийн бус” оролцогчид хэмээх ойлголт маш өргөн хүрээг хамардаг бөгөөд зэвсэгт бүлэглэлээс авахуулаад үндэстэн дамнасан корпораци гэх мэт бизнесийн байгууллагууд, мөн хувь хүмүүс ч мөн хамаарна. Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах гол үүргийг төр хүлээх ёстой боловч төрийн бус оролцогчид төртэй хамтран буюу дангаараа хүний эрхийн хамгаалагчдын эсрэг өдүүлсэн хэрэгт оролцож болно гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал. Зэвсэгт бүлэглэлүүд хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгохын тулд амь насыг нь бусниулах, хулгайлах, амь насанд нь заналхийлэх гэх мэт олон аргыг хэрэглэдэг. Эдгээр бүлэглэлүүдийн зарим нь засгийн газартай хуйвалдан үйл ажиллагаагаа явуулж байдаг бол нөгөө хэсэг нь засгийн газартай тэрсэлддэг сөрөг хүчний зэвсэгт бүлэглэлүүд байдаг.

Эдийн засгийн хувийн ашиг сонирхол, тухайлбал үндэстэн дамнасан корпораци буюу томоохон газар өмчлөгчид өөрсдийн байгаа нутгийн хүн ардын эдийн засаг, нийгмийн эрхэд ихээхэн нөлөө үзүүлдэг гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрөх болсон. Зарим оронд, үндэстэн дамнасан корпорацийн сөрөг үр нөлөөний эсрэг тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн хүний эрхийг хамгаалагчдын жагсаалыг дарахын тулд аюулаас хамгаалах байгууллага хүч хэрэглэх явдал гардаг. Нөгөө талаар, эдийн засгийн хувийн ашиг сонирхлыг өмгөөлсөн гэж сэжиглэгдэж буй үл таних хүмүүс хүний эрхийг хамгаалагчдын эрх чөлөөнд халдсан тохиолдолд засгийн эрх баригчид арга хэмжээ авч чадахгүй байх явдал тохиолддог. НҮБ-ын -Ерөнхий нарийн бичгээс томилогдсон Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч эдгээр халдлагын зарим нэг тохиолдолд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хамтран оролцсон, хариуцлага хүлээх ёстой гэдэг нь тов тодорхой байгаа тул түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг цохон тэмдэглэсэн байдаг.

Төрийн бус оролцогчдын үйлдлийн өөр нэг жишээ гэвэл, хүний эрхийг хамгаалагчид өөрсдийн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор шашны нийгэмлэг, нутгийн болон овгийн удирдагчид, тэр ч байтугай гэр бүлийнхээ гишүүдийн гарт амиа алдах, зодуулж, нүдүүлэх, айлган сүрдүүлэх явдлын золиос болж байдаг.

### **3. Төрийн ба төрийн бус оролцогчдын эерэг үүрэг роль**

Олон оронд төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргээ ерөнхийдөө үр дүнтэй хэргжүүлж байдгаас гадна улс бүрт дор хаяж, аюулгүй байдлын болон иргэний удирдах байгууллагуудад хүний эрхийг хамгаалахын төлөө мятаршгүй ажилладаг бөгөөд хүний эрхийг хамгаалагчийн үүргийг гүйцэтгэж байдаг хүмүүс бий. Зарим тохиолдолд, цагдаагийн ажилтан, шүүгчид, төрийн иргэний албан хаагчид болон улс төрчид бусад хүмүүсийн хүний эрхийг хамгаалахын төлөө, шударга ёсыг дэмжиж, авлигыг таслан зогсоохын төлөө учирч болох аливаа эрсдлээс үл шантран ажилладаг билээ. Түүний нэгэн адил, хувийн хэвшлийн зарим байгууллагууд хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчиж байхад зарим нь дэмжлэг туслалцаа үзүүлж байдаг. Үндэстэн дамнасан корпорациуд нь хүний эрхийг хэрэгжүүлэх асар том хүчин байж чадах бөгөөд зарим корпорациуд

---

хөдөлмөрийн талаар сайн бодлого баримталахын хамт салбараа нээсэн газрынхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Шашны удирдагчид хүний эрхийг болон хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үйлсийн тэргүүн эгнээнд зогсох нь олонтаа. Зарим тохиолдолд, төрийн бус оролцогчдыг эерэг ба сөрөг гэж нарийн зааглах боломжгүй байдаг. Учир нь бизнесийн ашиг сонирхол хүний эрхийн зарим төрөлд эерэгээр нөлөөлдөг атлаа заримд нь сөргөөр нөлөөлж болно. Тиймээс бизнесийн байгууллагууд болон бусад оролцогчид явуулж буй үйл ажиллагаа нь хүний эрхэд ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа талаархи хүний эрхийг хамгаалагчдын анхааруулгад анхаарлаа хандуулах нь хамгийн чухал юм.

### **III. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ НҮБ ХЭРХЭН ХАМГААЛДАГ БОЛОН ТЭДНИЙ АЖИЛД ҮЗҮҮЛДЭГ ДЭМЖЛЭГ**

НҮБ-аас явуулж буй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжсэн үйл ажиллагаа нь дараахи зүйлс дээр үндэслэдэг:

- Тухайн улсад олон улсын хүний эрхийн хэм хэмжээ хэрхэн хэрэгжих нь хувь хүмүүс болоод бүлгүүдийн (засаг захиргааны байгууллагад буюу түүнээс гадуур ажиллаж байгаа) оруулж буй хувь нэмрээс ихээхэн шалтгаалах бөгөөд тэдгээрээс хүний эрхийг хамгаалагчдад үзүүлж буй дэмжлэг туслалцаа нь хүний эрхийг бүх нийтээр хүндэтгэн сахих үндэс суурь болно;
- Засгийн газар, үндэсний хууль тогтоомж, цагдаагийн болон шүүхийн байгууллага, төр засаг нь бүхэлдээ тухайн оронд хүний эрхийг зөрчих явдлаас үр дүнтэй хамгаалж чадахгүй байгаа нөхцөлд хүний эрхийг хамгаалагчид хамгаалалтын хамгийн эцсийн хана хэрэм болдог;
- Хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн зөрчлийн бай болох нь түгээмэл байдаг. Учир нь тэдний явуулж буй хүний эрхийн үйл ажиллагаа болоод тэд өөрсдөө ч хамгаалуулах шаардлагатай байдаг.

ОИГ.МН  
СУДАЛГААНЫ САН

Хүний эрхийг хамгаалагчдын амин чухал үүрэг роль хийгээд тэдний олонхид тулгарч байдаг хүний эрхийн зөрчлүүд зэрэг нь НҮБ хүний эрхийг хамгаалагчид төдийгүй тэдний явуулж буй үйл ажиллагааг хамгаалахын тулд онцгой хүчин чармайлт тавих хэрэгтэй байгааг харуулсан билээ.

Энэ чиглэлд хийсэн хамгийн эхний том алхам бол хүний эрхийг “хамгаалах” гэдэг нь өөрөө хүний эрх мөн болохыг тодорхойлж, хүний эрхийн асуудлаар ажилладаг хүмүүсийг “хүний эрхийг хамгаалагчид” хэмээн хүлээн зөвшөөрсөн явдал мөн. 1998 оны 12 дугаар сарын 9-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблей 53/144 тоот тогтоолоороо Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглалыг (Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал гэдэг нэрээр олонд танигдсан) баталсан билээ.

Хоёр дахь алхам нь, 2000 оны 4 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Ерөнхий нарийн бичгийн даргаас уг тунхаглалын хэрэгжилтийг хянах, дэмжих үүрэг бүхий Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч томилохыг хүссэн явдал юм.

## **А. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал**

Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг боловсруулах ажил 1984 онд эхлэсэн бөгөөд 1998 онд Ерөнхий Ассемблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойг тохиолдуулан уг тунхаглалын эх бичвэрийг батласнаар дууссан юм. Олон тооны хүний эрхийн ТББ болон зарим улсын төлөөлөгчдийн хамтын хүчин чармайлтын үр дүнд эцсийн бүлэгт хүчтэй, маш хэрэгтэй бөгөөд прагматик эх бичвэр бий болсон билээ. Магадгүй хамгийн чухал нь, уг Тунхаглал зөвхөн улс орнууд болон хүний эрхийг хамгаалагчдад төдийгүй бүх хүмүүст хандаж буй явдал мөн. Тодруулбал, бид бүгдээрээ хүний эрхийг хамгаалагчийн үүргийг гүйцэтгэж болох бөгөөд бид бүхнийг хамарсан дэлхий нийтийн хүний эрхийн хөдөлгөөн байгаа гэдгийг онцолсон байдаг.

### **1. Эрх зүйн чадамж**

Тунхаглал угтаа хууль зүйн хувьд заавал биелэгдэх шинж агуулаагүй боловч түүнд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

---

ээрэг хууль зүйн хувьд заавал биелэгдэх шинжтэй хүний эрхийн олон улсын гэрээ конвенцид заасан хүний эрхийн хэм хэмжээнд тулгуурласан хэд хэдэн зарчим, эрхийг тусгасан билээ. Түүнчилэн, Тунхаглал Ерөнхий Ассемблейн зөвшилцлөөр батлагдсан учир улс орнууд түүнийг хэрэгжүүлэхэд хүчээ дайчлан ажиллах болно. Улс орнууд Тунхаглалыг үндэсний хэмжээнд эрх зүйн хувьд заавал биелэгдэх шинжтэй болгон батлах асуудлыг улам ихээр судлан үзэж байна.

## 1. Тунхаглалын заалт

Тунхаглал хүний эрхийг хамгаалагчдыг ажил үүргийнх нь хүрээнд дэмжлэг үзүүлэх, хамгаалах талаар заасан. Энэ нь хэдийгээр цоо шинэ эрхийг бий болгоогүй боловч одоогийн байгаа эрхийг хүний эрхийг хамгаалагчдын үүрэг роль, нөхцөл байдлын онцлогт тохируулан хэрэглэхэд тохиромжтой байдлаар тодорхойлсон болно. Тухайлбал, хүний эрхийг хамгаалагчдын байгууллага санхүүжилт хүлээн авах, хүний эрхийн хэм хэмжээ болон хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох зэрэгт анхаарал хандуулсан юм. Уг Тунхаглал үндэсний хууль тогтоомжтой хэрхэн холбогдох талаар зааснаас гадна хүний эрхийг хамгаалах талаар төрийн хүлээх онцгой үүрэг болон хүн бүрийн хүлээх үүрэг хариуцлагын тухай тусгасан байна. Тунхаглалын ихэнхи заалтыг доор дурьдлаа<sup>5</sup>. Тунхаглалд зааснаар хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаагаа тайван замаар явуулах ёстой гэдгийг ахин дурьдах нь чухал болов уу.

(a) Хүний эрхийг хамгаалагчдад олгох эрх ба хамгаалалт

Тунхаглалын 1, 5, 6, 7, 8, 9, 11, 12, 13-р зүйлд хүний эрхийг хамгаалагчдад онцгой хамгаалалт үзүүлнэ хэмээн заасан бөгөөд түүний дотор дараахи эрхийг эдлүүлнэ гэж заасан. Үүнд:

- Үндэсний ба олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхийг эрмэлзэх;
- Дангаараа болон бусадтай хамтран хүний эрхийн үйл ажиллагаа явуулах;
- Нийгэмлэг холбоо буюу ТББ байгуулах;
- Тайван замаар уулзалдах буюу эвлэлдэн нэгдэх;

---

<sup>5</sup>Тунхаглалын тухай илүү тодорхой мэдээлэл 2000 онд Хүний эрхийн зөвлөлийн 56-р чуулганд Ерөнхий нарийн бичгийн даргаас оруулсан тайланд бий. (E/CN.4/2000/95). Уг тайланд Тунхаглалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай саналуудыг багтаасан.

- Хүний эрхтэй холбоотой мэдээллийг эрж хайх, олж авах, хүлээн авах болон хадгалах;
- Хүний эрхийн холбогдолтой шинэ үзэл бодол, зарчмыг боловсруулах, хэлэлцэх болон тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэх талаар ажиллах;
- Засгийн газрын яам, агентлагуудад тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулах, хүний эрхийг сайжруулахад саад тотгор болж буй аливаа ажлынх нь талаар шүүмжлэл, саналаа хүргүүлэх;
- Хүний эрхтэй холбоотой албан ёсны бодлого, үйл ажиллагааны талаар гомдол мэдүүлэх, гомдлоо шийдвэрлүүлэх;
- Хүний эрхийг хамгаалахад мэргэжлийн хууль зүйн туслалцаа болон бусад зөвлөгөө, тусламж үзүүлэх;
- Олон нийтэд нээлттэй аливаа шүүх хурал, шүүх ажиллагаанд оролцох болон тэдгээрийг үндэсний хууль тогтоомж болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд үнэлэлт өгөх;
- ТББ болон засгийн газар хоорондын байгууллагуудад саадгүйгээр нэвтрэх, чөлөөтэй харилцах;
- Үр дүнтэй хууль зүйн хамгаалалтаар хангагдах;
- Хүний эрхийн хамгаалагчийн мэргэжил, албан тушаалыг хууль ёсоор хэрэгжүүлэх;
- Хүний эрхийг зөрчиж байгаа төрийн аливаа үйлдэл, эс үйлдлийн эсрэг тайван замаар тэмцэх явдлыг үндэсний хууль тогтоомжоор үр дүнтэй хамгаалах;
- Хүний эрхийг хамгаалах зорилгоор санхүүжилт хүсэх, хүлээж авах, ашиглах (түүний дотор гадаадаас санхүүжилт авах).

#### (б) Улсуудын үүрэг

Улсууд Тунхаглалын бүх заалтыг дагаж мөрдөн, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Гэхдээ 2, 9, 12, 14, 15-р зүйлд Улсуудын үүргийг онцгойлон заасан бөгөөд Улс бүр дараахи үүргийг хүлээнэ:

- Хүний эрхийн бүх төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэх;
- Ард түмэндээ нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлүүлэх;
- Хүний эрх, эрх чөлөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүй, захиргааны болон бусад арга хэмжээг авах;
- Хүний эрхийн зөрчлийн хохирогч болсон хэмээн гомдол гаргагчид хууль зүйн үр дүнтэй хамгаалалт үзүүлэх;


- 
- Хүний эрхийн зөрчлийн талаар цаг алдалгүй, шударга мөрдөн байцаалт явуулах;
  - Ямар ч хүн Тунхаглалд заасан хууль ёсны эрхээ хэрэгжүүлсний улмаас аливаа хүчирхийлэл, заналхийлэл, элдэв дайралт, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт болон бусад хууль бус үйл ажиллагааны золиос болохоос хамгаалах шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
  - Иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх;
  - Омбудсмен, хүний эрхийн хороо гэх мэт хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилготой үндэсний бие даасан байгууллагыг бий болгох, хөгжүүлэхэд анхаарах;
  - Албан ёсны боловсролын бүх төвшин болон мэргэжлийн сургалтад хүний эрхийн хичээл заах явдлыг хөхиүлэн дэмжих, хөнгөвчлөх.

(в) Хүн бүрийн хүлээх хариуцлага

Тунхаглалд хүн бүр орон нутгийнхаа өмнө үүрэг хүлээдэг бөгөөд хүн бүр хүний эрхийг хамгаалагч байж чадна гэдгийг онцлон заасан юм. Тунхаглалын 10, 11, 18-р зүйлд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ардчиллыг болон ардчилсан байгууламжийг хамгаалах, бусдын хүний эрхийг зөрчихгүй байх талаар хүн бүрийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон. 11-р зүйлд бусдын хүний эрхэд нөлөөлж болохуйц цагдаагийн ажилтан, хуульч, шүүгч гэх мэт мэргэжлээр ажилладаг хүмүүсийн хүлээх үүрэг хариуцлагын талаар тусгайлан заасан байна.

(г) Үндэсний хууль тогтоомжийн үүрэг

Тунхаглалын 3, 4-р зүйлд хүний эрхийн хууль зүйн хамгийн өндөр хэм хэмжээг хэрэгжүүлэх талаар үндэсний болон олон улсын эрх зүйтэй уг тунхаглал хэрхэн харилцах тухай заасан.



## **Б. Ерөнхий нарийн бичгийн даргын Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч**

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2000 оны 4-р сарын 26-ны 2000/61-р тогтоолоороо Ерөнхий нарийн бичгийн даргаас Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч томилохыг хүссэн. Ингэхдээ Зөвлөл уг тунхаглалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, дэлхий даяар хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдал ямар байгаа талаар мэдээлэл цуглуулахыг эрмэлзсэн билээ. 2000 оны 8-р сард Ерөнхий нарийн бичгийн дарга хатагтай Хина Жиланиг энэхүү албан тушаалыг хаших анхны хүнээр томилсон юм.

### ***1. Тусгай төлөөлөгчийн албан ёсны бүрэн эрх***

Тусгай төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааг аливаа улсаас хараат бусаар явуулах бөгөөд НҮБ-ын албан хаагч биш, мөн тэндээс цалин хөлс авахгүй. Хүний эрхийн зөвлөлийн 2000/61 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд заасны дагуу Тусгай төлөөлөгчийн бүрэн эрхэд дараахи үйл ажиллагаа багтана:

- (а) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахаар дангаараа буюу бусадтай нэгдэн үйл ажилллагаа явуулж буй хэн бүхний эрх, нөхцөл байдлын талаар мэдээлэл хайх, хүлээн авах, шалгах болон түүнд хариулт өгөх;
- (б) Тунхаглалыг хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэх талаар засгийн газар болон бусад сонирхогч этгээдтэй хамтран ажиллах, яриа хэлэлцээ явуулах;
- (в) Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах илүү үр дүнтэй стратегийг зөвлөмж болгох, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

Хүний эрхийн зөвлөл бүх засгийн газрыг Тусгай төлөөлөгчтэй хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, түүнийг хүссэн бүх мэдээллээр нь хангахыг уриалсан байна. Түүний зэрэгцээ Тусгай төлөөлөгчийг жил бүр тайлан бэлтгэж Ерөнхий Ассемблейд оруулж байхыг хүсжээ.

### ***2. Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаа***

Тусгай төлөөлөгчийн албан ёсны бүрэн эрх маш өргөн тул түүнийг хэрэгжүүлэх стратеги, нэн тэргүүнд анхаарах зүйлс болон үйл



---

ажиллагаагаа тодорхойлох шаардлага тулгарч байна. Хүний эрхийг хамгаалагчдыг “хамгаалах” нь Тусгай төлөөлөгчийн нэн тэргүүний зорилт билээ. Хамгаалалт гэдэгт хүний эрхийг хамгаалагчдыг өөрсдийг нь хамгаалахаас гадна тэдний хүний эрхийг сахин хамгаалах явдал багтана. Тусгай төлөөлөгч өөрийн бүрэн эрх маш өргөн хүрээг хамарсан байдгийг санаж, орон бүрт адил хэм хэмжээ үйлчилж байхад онцгой анхаарна. Хэдийгээр заримдаа уялдаа холбоо муутай байдаг ч, олон янзын зорилготой нэлээд өргөн хүрээтэй үйл ажиллагааг авч хэрэгжүүлдэг юм.

*(a) Хүний эрхийг хамгаалагчидтай харилцах*

Хамгийн гол нь, Тусгай төлөөлөгч хүний эрхийг хамгаалагчидтай доорхи зарчмаар хамтран ажиллана:

- Хүний эрхийг хамгаалагчдаас ирүүлсэн мэдээлэл, түүний дотор тэдний эсрэг үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийн талаархи мэдээллийг хүлээн авах, (доор байгаа (d) “Тодорхой тохиолдлууд”-ыг үзнэ үү) түүн дээр үндэслэн тулгамдсан асуудлыг тодорхойлж, улсуудад хандах;
- Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүний эрхийг хамгаалагчидтай уулзах сайхан боломж олгодог үндэсний, бүсийн, олон улсын хэмжээний хүний эрхийн үйл явдалд тогтмол оролцох (түүний дотор Хүний эрхийн зөвлөлийн жил бүрийн чуулганд оролцох).

*(б) Улсуудтай харилцах*

Тусгай төлөөлөгч улсуудтай тогтмол харилцана. Женев дэх Хүний эрхийн зөвлөлийн жил бүрийн чуулган, Нью Йоркт болдог Ерөнхий Ассемблейн чуулганаар дамжуулан ерөнхий харилцаагаа хэрэгжүүлнэ. Ерөнхий Ассемблейн чуулганд Тусгай төлөөлөгч өөрийн жил бүрийн тайланг улс орнуудад танилцуулж, тэдний асуултад хариулж, тулгамдсан асуудлаар, түүний дотор тодорхой хэрэг явдлын талаар улсуудын төлөөлөгчидтэй уулзах боломжтой. Харин илүү тусгай харилцааг хоёр талын уулзалт, захидал харилцаагаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд эдгээрийг Тусгай төлөөлөгч тухайн улстай тодорхой асуудлыг хөндөх, тодорхой хэргийн талаар буюу тухайн улсад айлчлах урилга авах зэрэгт түүний дэмжлэгийг авахад хэрэглэнэ.

---

*(в) Бусад чухал оролцогчидтой харилцах*

Тусгай төлөөлөгч жилийн турш бүрэн эрх болон үйл ажиллагааныхаа хүрээнд бусад олон тооны оролцогчидтой, түүний дотор үндэсний парламент, бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллага болон хүний эрхийн хамгаалагчдын үүрэг роль, нөхцөл байдлыг дээшлүүлэхийг эрмэлзэж буй улс орнуудтай уулзана.

*(г) Тодорхой тохиолдлууд*

Тусгай төлөөлөгч хүний эрхийн хамгаалагчдын эсрэг хүний эрхийн зөрчлийн тодорхой тохиолдлуудын талаар улс орнуудтай хамтран ажиллана. Тэдгээрийн тухай мэдээллийг засгийн газар, ТББ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хэвлэл мэдээлэл болон хүний эрхийн хамгаалагчид зэрэг төрөл бүрийн эх сурвалжаас хүлээн авна. Тусгай төлөөлөгч нь тухайн мэдээлэл ирмэгц, өөрийн бүрэн эрхэд хамаарах эсэхийг тодорхойлно. Хоёрдугаарт, уг хүний эрхийн зөрчил үнэхээр гарсан эсэх болон мэдээллийн эх сурвалж хэр зэрэг найдвартай болохыг тодорхойлохыг бүхий л чадлаараа чармайна. Гуравдугаарт, Тусгай төлөөлөгч тухайн зөрчил гарсан улсын Засгийн газартай холбоо тогтооно. Ийнхүү холбоо тогтоохдоо иэвчлэн тухайн улсын Гадаад Хэргийн Яаманд “яаралтай арга хэмжээний захидал” буюу “мэдэгдэх захидал” -ыг хүргүүлэх бөгөөд хувийг Женев дэх тус улсын НҮБ-д суугаа Байнгын Төлөөлөгчийн Газарт илгээнэ. Захидалд хохирогчийн тухай мэдээлэл, хүний эрхийн тулгамдсан асуудал болон болсон үйл явдлын талаар дурьдана. Захидлын нэн тэргүүний зорилго бол тухайн улсын засаг захиргаанд аль болох цаг алдалгүй мэдэгдэх явдал бөгөөд ингэснээр тэд тухайн асуудлыг мөрдөн шалгах, хүний эрхийн аливаа зөрчлийг таслан зогсоох буюу түүнээс урьдчилан сэргийлэх боломжтой болох юм.

“Яаралтай арга хэмжээний” захидлыг гарч байгаа буюу гарч болзошгүй хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл хүргэхэд ашиглана. Гол зорилго нь нөхцөл байдлын талаар засгийн эрх баригчдад аль болох хурдан мэдээлэх, ингэснээрээ тухайн зөрчлийг таслан зогсоох буюу түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж олгох явдал юм. Жишээ нь, хүний эрхийн үйл ажиллагаатай нь холбогдуулан нэгэн хүний эрхийн хуульчийн амь насанд халдахаар заналхийлсэн тухай яаралтай арга хэмжээний захидлаар мэдэгдэж болно.

---

“Мэдэгдэх” захидлыг тухайн зөрчил болоод өнгөрсөн бөгөөд хүний эрхийг хамгаалагчид үзүүлсэн нөлөөг эргүүлж өөрчлөх боломжгүй болсон үед хэрэглэнэ. Энэ төрлийн захидлыг тухайн хүний эрхийн зөрчил гараад нэлээд удсан бөгөөд ямар нэг дүгнэлтэд хүрсний дараа Тусгай төлөөлөгчид энэ тухай мэдээлэл очсон тохиолдолд хэрэглэдэг. Жишээ нь, хүний эрхийг хамгаалагчийг алсан тохиолдолд харьяалах улсад нь мэдэгдэх захидал илгээнэ.

Дээрх 2 төрлийн захидлын аль алинд, Тусгай төлөөлөгч холбогдох Засгийн газраас болсон үйл явдлыг мөрдөн шалгах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч, түүнийхээ үр дүнгийн талаар мэдэгдэхийг хүсдэг. Мэдэгдэх захидалд гол нь засгийн эрх баригчдаас тухайн үйл явдлыг мөрдөн шалгах, буруутай этгээдүүдийг эрүүгийн хуулиар шийтгэхийг хүссэн байдаг. Засгийн газрууд руу илгээсэн захидал нь нууцын зэрэглэлд хамаарах бөгөөд тайлант жилийг дуустал буюу Тусгай төлөөлөгч тодорхой тохиолдлын талаар засгийн газруудтай харилцсан тухай Хүний Эрхийн Хороонд жилийн тайлангаа танилцуулах хүртэл уг статусаа хадгална. Тусгай төлөөлөгч нь тодорхой асуудлаар бүрэн эрхтэй НҮБ-ын тусгай илтгэгчидтэй байнга зөвлөлддөг бөгөөд тэдгээрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хамтарсан захидлыг илгээх нь олонтаа. Энэхүү гарын авлагын Хавсралт 2-т тодорхой тохиолдлын талаар арга хэмжээ авахын тулд Тусгай төлөөлөгчдөд шаардагдах мэдээлэл, тэрхүү мэдээллийг хэрхэн илгээх талаар зааварчилгааг багтаасан болно.

*(д) Улс оронд айлчлах*

Тусгай төлөөлөгч нь улс орнуудад айлчлах бүрэн эрхтэй. Зарим улс түүнд байнгын урилга гардуулсан байдаг бөгөөд бусад тохиолдолд Тусгай төлөөлөгч тухайн засгийн газарт урилга ирүүлэхийг хүсч захидал бичдэг. Эдгээр айлчлалын үеэр тухайн улс дахь хүний эрхийг хамгаалагчдын үүрэг роль болон нөхцөл байдлыг нарийвчлан шалгах, бэрхшээлтэй асуудлыг олж тодруулах, тэдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгдөг. Бүрэн эрхийнхээ дагуу, Тусгай төлөөлөгч нь тухайн орон дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар шүүмжлэлтэй хандах ёстой. Хэдий тийм боловч, энэхүү үйл ажиллагаа нь бие даасан, аль нэг талыг бариагүй үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэх учиртай бөгөөд хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг бэхжүүлэх, тэднийг хамгаалахад хэрэглэгдэх учиртай.

---

Эдгээр айлчлал нь ихэнхидээ 5-10 өдөр үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд Тусгай төлөөлөгч төр засгийн тэргүүн, холбогдох засгийн газрын сайд, хүний эрхийн бие даасан байгууллага, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хэвлэл мэдээллийнхэн болон хүний эрхийг хамгаалагчидтай уулздаг. Айлчлалын үеэр хөнддөг сэдэв гэвэл хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зөрчил, хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаагаа явуулах “орчныг” сайжруулах, түүний дотор эвлэлдэн нэгдэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үндэсний хууль тогтоомжоор хүний эрхийг хамгаалагчдад санхүүжилт, дэмжлэг тусалцаа авах эрх олгох, эрх баригчдын зүгээс хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн зөрчлөөс хамгаалах талаар ямар хүч чармайлт тавьж байгаа зэрэг асуудал болно. Айлчлал өнгөрснөөс хэдэн сарын дараа, Тусгай төлөөлөгч айлчлалын тухай, сэтгэл зовоосон асуудлууд болон авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаархи зөвлөмжүүдийг багтаасан тайлан гаргадаг. Тайланг Хүний Эрхийн Хорооны чуулганд албан ёсоор танилцуулна.

*(e) Семинар, бага хурал*

Тусгай төлөөлөгч жил бүр хүний эрхийг хамгаалагчдын талаар буюу тэдгээртэй холбоотой илүү өргөн хүрээтэй асуудал, тухайлбал ардчилах үйл явцын талаар олон тооны семинар, бага хуралд оролцдог. Эдгээр арга хэмжээг улсууд, НҮБ, их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон бусад оролцогчид зохион байгуулдаг.

*(ё) Стратеги*

Тусгай төлөөлөгч дэлхийн нийт хүний эрхийг хамгаалагчдын үүрэг роль, нөхцөл байдалд шууд нөлөөлдөг асуудлуудыг тодорхойлохын сацуу чухам энэ чиглэлээр явуулах үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрхийг хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх ёстой. Эдгээр асуудалд ардчиллын үйл явц, орон нутгийн эрх баригчдын үүрэг хариуцлага, аюулгүй байдлын болон терроризмын эсрэг хууль тогтоомж хүний эрхийн хамгаалагчдад ямар нөлөө үзүүлж байгаа зэрэг багтана. Хүний эрхийн хамгаалагчдыг дэмжих хамгийн тохиромжтой стратеги бол тэдэнд зориулсан бүс нутгийн хамгаалалтын сүлжээ байгуулах явдал юм.

---

(ж) Тайлан

Тусгай төлөөлөгч бүрэн эрхийнхээ дагуу жил бүр Хүний Эрхийн Хороо болон Ерөнхий Ассамблейд гаргаж өгдөг тайландаа тухайн жилд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тайлагнаж, гол хандлага болон ноцтой асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж гаргаж өгдөг. Зарим тайланд тулгамдаж буй томоохон асуудалд, тухайлбал аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж хүний эрхийг хамгаалагчид болон тэдний ажилд ямар нөлөө үзүүлж байгаа талаар дүн шинжилгээ хийдэг. Энэхүү тайлан нь тодорхой улс буюу бүс нутагт хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг саад бэрхшээл болон дэлхий нийтэд тулгарч буй асуудлуудыг тодорхой харуулсан чухал баримт юм. Тайлан бүрт тодорхойлсон зөвлөмжүүд нь улс орнууд, НҮБ, хүний эрхийг хамгаалагчид болон хувийн хэвшлийнхний авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсийг тодорхойлдог. Тусгай төлөөлөгчийн илтгэлийг НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын цахим хуудаснаас үзэж болно. ([www.ohchr.org](http://www.ohchr.org)). Дээр дурдсан бүх бүлгийн үйл ажиллагааны зорилго бол хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, Тунхаглалыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм.

### 3. Хангамжийн болон нөөцийн зохицуулалт-ХЭДКГ-ын үүрэг

НҮБ-ын тусгай илтгэгчдийн нэгэн адил<sup>6</sup>, Тусгай төлөөлөгч зөвхөн хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэртэй байдаг тул баримталж буй стратеги, явуулж буй үйл ажиллагаагаа түүндээ тохируулах шаардлагатай байдаг. Тусгай төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл хэрэгтээ НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас, тэр дундаа тэндэхийн тодорхой асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс маш их туслалцаа дэмжлэг авдаг.<sup>7</sup> Эдгээр нь Женевт төвтэй ХЭДКГ-ын ажилтнууд бөгөөд бүрэн эрх хэрэгжүүлэгчийн удирдлага дор Хүний Эрхийн Хорооноос томилогдсон тусгай төлөөлөгчийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг хүлээдэг. Жишээ нь, ДДКГ-ын мэргэжилтнүүд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зөрчлийн талаар мэдээлэл тогтмол хүлээж авдаг ба тэд уг мэдээлэлд дүн шинжилгээ хийгээд Тусгай төлөөлөгчид мэдэгдэнэ. Мөн тэд Тусгай төлөөлөгчид тайлангаа боловсруулах, улс орнуудад хийх айлчлалын

---

<sup>6</sup> НҮБ-ын тусгай илтгэгчдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Fact Sheet No. 27-оос үзнэ үү.

<sup>7</sup> Санхүүгийн боломжоос шалтгаалаад Тусгай төлөөлөгчид нэгээс олон хүн дэмжлэг үзүүлж болно.

---

бэлтгэлийг хангахад нь тусладаг. Тусгай төлөөлөгчийн элчин сайдын яамд, ТББ буюу НҮБ-ын ажилтнуудтай хийдэг уулзалт, өдөр тутмын харилцаанд ихэнхи тохиолдолд дээрх мэргэжилтнүүд оролцдог. ДДКГ-ын захиргаа, үйлчилгээний байгууллага томилолт болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэхэд тусалцаа үзүүлдэг. НҮБ-ын төсвөөс Тусгай төлөөлөгчид жилд хоёр удаа албан ёсны айлчлал хийх, Хүний Эрхийн Хорооны болон Ерөнхий Ассемблейн чуулганд оролцох, мөн Женевт болдог зөвлөлдөх уулзалтад оролцох зэрэгт замын зардлыг санхүүжүүлэх бага хэмжээний хөрөнгө гаргаж өгдөг. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон ТББ-ууд зарим үед семинар зохион байгуулах, судалгааны тайлан хэвлэх, бусад ерөнхий арга хэмжээнд зориулан Тусгай төлөөлөгчид нэмэлт санхүүжилт олгодог. Тусгай төлөөлөгчтэй хэрхэн холбоо тогтоох талаар энэхүү гарын авлагын Хавсралт 2-т дурдсан бөгөөд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зөрчлийн талаарх мэдээллийг хэрхэн дамжуулах талаар зааврыг үзэж болно.

#### **IV. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ АЖЛАА ХИЙХЭД НЬ ХЭРХЭН ДЭМЖИЖ, ХАМГААЛАХ ВЭ?**

Хүний эрхийн ноцтой зөрчлийн дийлэнхи хэсэг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг чиглэгдэж байгаа нь тэдний үүрэг ролийг дэмжих, эрсдлээс хамгаалах талаар илүү их зүйл хийх хэрэгтэй байгааг харуулж байна. Энэхүү бүлэгт Тунхаглалыг хэрэгжүүлэх, тэгснээрээ хүний эрхийг хамгаалагчдыг орон нутаг, үндэсний, бүсийн болон олон улсын төвшинд хамгаалахын тулд авч хэрэгжүүлж болох үйл ажиллагааны талаар олон саналыг багтаасан болно. Эдгээр санал нь засгийн газар, хүний эрхийг хамгаалагчдад өөрсдөд нь, иргэний нийгэм, НҮБ болон зарим тохиолдолд хувийн хэвшлийнхэн буюу бусад оролцогчдод хандсан билээ. Хэдийгээр энэ нь юу хийж болох талаархи бүрэн дүүрэн жагсаалт биш ч гэсэн бүс нутаг, улс орон бүрийн онцлогийг харгалзан тодорхой үйл ажиллагаа, стратегийг явуулах үндсэн ойлголт болж чадна.<sup>8</sup> Эдгээр саналд дараахи зүйлс багтаж байна:

---

<sup>8</sup> Үйл ажиллагааны талаар нэмэлт зөвлөмжийг 2000 онд Ерөнхий нарийн бичгийн даргын Хүний Эрхийн хороонд өргөн барьсан тайлан (E/CN.4/2000/95) болон Тусгай төлөөлөгчийн Ерөнхий Ассемблейд (A/56/341, A/57/182 and A/58/380, хавсралт) болон Хүний Эрхийн Хороонд гаргаж өгсөн тайлангуудаас (E/CN.4/2001/94, E/CN.4/2002/106 Add.1 and 2 and E/CN.4/2003/104 Add.1-4) үзэж болно. Тусгай төлөөлөгчийн эдгээр тайланг ХЭДКГ-ийн цахим хуудаснаас үзэж болно. ([www.ohchr.org](http://www.ohchr.org))

- 
- Хүний эрхийг хамгаалагчдын ажил болон тэднийг хамгаалах хууль зүйн үндэс, түүний дотор үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулах;
  - Хуулиар хамгаалуулах;
  - Сургалтад хамрагдах, мэдээллээр хангагдах;
  - Орон нутгийн болон үндэсний эрх баригчид, НҮБ-ын үүрэг роль ба хувийн хэвшлийнхний нөлөөлөх хүч чадал;
  - Хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн албан бус сүлжээгээр дамжуулан хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар хяналт тавих, мэдээллийг түгээх;
  - Гадаадын хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, дэмжих;
  - Хүний эрхийг хамгаалагчдад тавигдах үүрэг хариуцлага, өндөр хэм хэмжээ.

Дахин онцлон хэлэхэд, хүний эрхийг хамгаалагчдад үзүүлж буй дэмжлэг туслалцаа, хамгаалалт нь мөн хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд тус дөхөм болдог. Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах, тэдний ажлыг дэмжиж туслах нь улсуудын хүний эрхийн стратегийн болон НҮБ-ын бүхий л үйл ажиллагаа, мөн түүнчлэн холбогдох төрийн бус байгууллагын үйл ажиллагааны гол цөм байх ёстой. Хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих явдал хөгжил, ардчилах үйл явц болон тэдгээртэй төстэй бусад хүрэн дэх олон улсын хамтын ажиллагааны салшгүй нэгэн хэсэг байх ёстой.

## **А. Улсуудын үйл ажиллагаа**

Ерөнхий Ассемблей 1998 оноос эхлэн Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалын талаар жил бүр тогтоол гаргах болсон бөгөөд бүх улс оронд тунхаглалыг хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэхийг уриалсан<sup>9</sup>. Хүний Эрхийн Хорооны 2000 оноос гаргаж эхлэсэн жил бүрийн тогтоолд мөн бүх улсуудад тунхаглалыг хэрэгжүүлэх, Тусгай төлөөлөгчтэй хамтран ажиллах, түүнд туслалцаа дэмжлэг, үзүүлэхийг уриалсан.<sup>10</sup> Эдгээр тогтоол улс бүрийн болон олон улсын хамтын нийгэмлэгийн улс төрийн зориг эрмэлзлэлийг тусган харуулж байна. Улсууд ямар тодорхой үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх боломжтой талаар доор өгүүлэв.

---

<sup>9</sup> Ерөнхий Ассемблейн 2001 оны 12-р сарын 19-ний 56/163 тоот тогтоол болон 2002 оны 12-р сарын 18-ны 57/209 тоот тогтоолыг үзнэ үү.

<sup>10</sup> Хүний Эрхийн Хорооны 2000 оны 4-р сарын 26-ны 2000/61 тоот тогтоол, 2001 оны 4-р сарын 25-ны 2001/64 тоот тогтоол, 2002 оны 4-р сарын 25-ны 2002/70 тоот тогтоол, 2003 оны 4-р сарын 24-ний 2003/64 тоот тогтоолыг үзнэ үү.

---

## 1. Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг хэрэглэх

- Дотоодын хууль тогтоомж Тунхаглалтай нийцэж буй эсэх: Дотоодын хууль тогтоомжоо Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалтай нийцүүлэх. Хүний эрхийг хамгаалагчдын санхүүжилт авах, бие даасан байдлаа хадгалах, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хууль зүйн ямарваа нэг саад тотгор учруулахгүй байх талаар онцгой анхаарах.
- Тунхаглалыг үндэсний хууль тогтоомжийнхоо бүрэлдэхүүн хэсэг болгох: Тунхаглалыг үндэсний хэмжээнд заавал дагаж мөрдөх хууль зүйн баримт бичиг болгон батлах нь хүний эрх болоод хүний эрхийг хамгаалагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх нэн чухал арга хэрэгсэл болгоно. Ийнхүү дотоодын хууль тогтоомжийн нэгэн хэсэг болгосноор шүүхийн байгууллага түүнийг хэрэглэх, төрийн захиргааны байгууллагууд дагаж мөрдөх явдлыг ихээхэн хөнгөвчлөх болно.
- Тунхаглалыг хэрэгжүүлэх: Тунхаглалын заалтыг хэрэгжүүлж, гарсан ахиц дэвшлийг хянаж, 2 жил тутам ямар арга хэмжээ авсан, сэтгэл зовоож буй ямар асуудал үүдсэн талаар тайлан бичиж нийтлүүлнэ. Тунхаглалыг хэрэгжүүлэх талаар иргэний нийгэмтэй зөвшилцөж, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж нийтлүүлэх.
- Тунхаглалыг түгээн дэлгэрүүлэх, сургалт явуулах: Мэдээлэл, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан тунхаглалыг түгээн дэлгэрүүлэх, ингэхдээ хүний эрхийг хамгаалагчид, төрийн албан хаагчид, засгийн газар хоорондын байгууллагууд болон хэвлэл мэдээллийнхнийг татан оролцуулах.

## 2. Бодит байдал дээрх хамгаалалт

- Хяналт тавих: Хүний эрхийн үндэсний хороо гэх мэтчилэн хүчтэй, биеэ даасан, санхүүжилт сайтай, хүний эрхийн хамгаалагчдаас ажиллаж байгаа буюу өөрсдийнх нь эсрэг чиглэсэн хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах. Хүний эрхийн хяналтын бүс нутгийн механизмыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ нь хүний эрхийн хамгаалагчдад нэмэлт хамгаалалт болж чадна.
- Шударга ёс ба ял шийтгэлгүй үлдэх явдал: Хүний эрхийг хамгаалагчид шүүхийн байгууллагын бүрэн хамгаалалтад байх, тэдний эсрэг үйлдэгдсэн аливаа зөрчлийг цаг алдалгүй, нухацтай мөрдөн шалгах, зохих нөхөн олговор олгох.
- Орон нутгийн засаг захиргааны үүрэг: Хүний эрхийг хамгаалагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамгаалах үйл хэрэгт орон нутгийн



---

засаг захиргааны үүрэг ролийг онцлон авч үзэх. Тунхаглалыг хэрэгжүүлэх ажил орон нутгийн болоод үндэсний хэмжээнд явагдах ёстой.

- Засаглалын эрх мэдлийн төвлөрөлийг сааруулах үйл явцыг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлага орон нутгийн төдийгүй үндэсний засгийн газарт ногдох учиртай гэдгийг санах учиртай. Орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнууд хүний эрхийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж, хүний эрхийн хэм хэмжээг дагаж мөрдөх үйл хэрэгтээ үндэсний засаг захиргаанаас дэмжлэг авах ёстой. Тунхаглалын хэрэгжилтийн талаар жил бүрийн үндэсний тайланд орон нутгийн засаг захиргаа мэдээлэл өгч, хувь нэмрээ оруулж болно.
- Тусгай төлөөлөгчтэй хамтран ажиллах: Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаар болон Хүний эрхийн Хорооноос олгосон бүрэн эрхийн бусад асуудлаар тухайн оронд айлчлах Тусгай төлөөлөгчид байнгын хүчинтэй урилга илгээх. Тусгай төлөөлөгчийн хөндсөн асуудалд алгууралгүй хариу өгөх, түүний тайланд дурдагдсан зөвлөмжийг анхааран ажиллах.

### 3. Төрийн байгууллагын авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хууль тогтоох байгууллага Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглалыг дэмжсэн мөрийн хөтөлбөр батлах; аюулгүй байдлын тухай гэх мэт хууль дүрмийг хүний эрхийн хамгаалагчдын ажлыг хязгаарлахад буруугаар ашиглахгүй байх талаар онцгой анхаарал тавих; хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн парламентийн хороо байгуулах; парламентийн гишүүд аюул заналхийлэл дор байгаа хүний эрхийн хамгаалагчдыг “ивээлдээ авах”, тэднийг олон нийтэд нээлттэйгээр өмгөөлөх. Энэхүү санаачилгыг тухайн улсын хүний эрхийн хамгаалагчдын төлөө ашиглаж болохоос гадна мөн бусад улсын хүний эрхийн хамгаалагчдын төлөө ч ашиглаж болно.
- Төрийн тэргүүн буюу засгийн газрын тэргүүний ажлын алба нь засгийн газрын бүх яамд өөрсдийн ажил үүрэгт хамаарах хүрээнд хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжиж туслах явдлыг хангах гол тулгуур байх учиртай.
- Гадаад Хэргийн Яам өөр оронд ажиллаж байгаа хүний эрхийг хамгаалагчдын гаргасан саналыг засгийн газрын гадаад бодлого болон олон улсын худалдааны үйл ажиллагаанд тусгах талаар ажиллана. Түүнчлэн, өөр улсад мөрдөн мөшгигдөхөөс зугатааж буй хүний эрхийг хамгаалагчдад өөрийн оронд орох асуудлыг

---

хөнгөвчлөх, түр зуур оршин суух эрх олгох зэргээр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

- Дотоод Хэргийн Яам дотоодын аюулгүй байдлын бүх ажилтнууд, түүний дотор цагдаа нарт хүний эрхийн сургалт явуулах, тэднийг хүний эрхийг хамгаалагчдын үүрэг ролийг дэмждэг, Тунхаглалд заасан эрх үүргээ биелүүлдэг байхад анхааран ажиллах учиртай.

## **Б. Төрийн бус оролцогчид, тэр дундаа иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхний үйл ажиллагаа**

- **Хэвлэл мэдээллийн хэрэгсэл:** Тунхаглалын талаар мэдээлэл түгээх, хүний эрхийг хамгаалагчдын эсрэг өдүүлсэн зөрчлийн талаар мэдээлэх, тэдний ажилд олон нийтээс үзүүлж буй дэмжлэг туслалцааг сурталчлах зэргээр хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих үйл хэрэгт амин чухал үүрэг гүйцэтгэж чадна. Үүнтэй холбогдуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг ролийг бэхжүүлэх санаачилгыг хэвлэл мэдээллийн болон бусад ТББ-ууд гаргаж болох бөгөөд хүний эрхийн сургалт зохион байгуулах, хүний эрхийн асуудлаарх мэдээллийг тогтмол авах бололцоог нэмэгдүүлэх зэрэгт анхаарах. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүний эрхийг хамгаалагчдын нэр төрийг гутаах зорилгоор террорист, гэмт хэрэгтнүүд, төрийн эсрэг хуйвалдагчид гэх мэт худал мэдээлэлд цаг алдалгүй няцаалт өгөх талаар онцгой хүчин чармайлт гаргах.

- **Үндэстэн дамнасан корпорациуд** өөрсдөд нь хандсан хүний эрхийг хамгаалагчдын зүй ёсны шаардлагад анхааралтай хандах ёстой. Ялангуяа, үндэстэн дамнасан корпорацийн талаар шүүмжлэл өрнүүлж буй хүний эрхийг хамгаалагчдын эсрэг төрийн эрх баригчдын зүгээс хүч хэрэглэх явдлыг ил буюу далдуур хүсэх, өөгшүүлэн дэмжихгүй байх талаар онцгой анхаарах ёстой. Түүнчлэн, тухайн улстай худалдааны болон бусад гэрээ хэлэлцээр байгуулах үеэр хүний эрхийг хамгаалагчдын эсрэг гарсан хүний эрхийн аливаа зөрчлийн талаар сэтгэл зовниж байгаагаа эрх баригчдад илэрхийлж болно. Үндэстэн дамнасан корпорациуд буюу бусад хувийн хэвшлийн байгууллагууд хүний эрхийг хамгаалагчдад хэрхэн хандах талаар бодлогоо боловсруулахдаа Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал болон НҮБ-ын Даяаршлын Тунхаг хөтөлбөрийг ашиглаж болно.<sup>11</sup>

---

<sup>11</sup> [www.unglobalcompact.org](http://www.unglobalcompact.org) хуудсыг үзнэ үү.

- 
- **Дэмжигч сүлжээ:** Иргэний нийгмийн байгууллагууд албан бус хяналтын сүлжээ байгуулж болох бөгөөд ингэснээрээ хэн нэгэн хүний эрхийг хамгаалагчийн эсрэг зөрчил гарсан тухай мэдээллийг өргөн хүрээнд хурдан дамжуулж чадна. Ийм хяналт нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд туслах хүчтэй хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг. Уг сүлжээг орон нутгийн төдийгүй, үндэсний болон бүсийн хэмжээнд байгуулах нь зүйтэй юм. Олон улсын хүний эрхийн ТББ-ууд зэрэг олон улсын холбогдох механизмтай хэлхээ холбоотой ажиллах ёстой.

## **В. НҮБ-ын газар, хэлтэс, төрөлжсөн байгууллага, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа**

Хүний эрхийг хамгаалагчдын тухай Ерөнхий Ассемблейгаас гаргадаг жил бүрийн тогтоолд НҮБ-ын холбогдох бүх төрөлжсөн байгууллагуудыг өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгчид боломжтой бүх туслалцаа дэмжлэг үзүүлэхийг уриалсан. Мөн түүнчлэн, НҮБ-ын санал санаачилгууд, тухайлбал Ерөнхий нарийн бичгийн даргын тус байгууллагын хөтөлбөрт хүний эрхийн асуудлыг илүүтэй тусгахад үзүүлж буй дэмжлэг, НҮБ-ын шинэчлэлийн үйл явц, 2000 оны Мянганы Дээд хэмжээний уулзалтаар улсуудын баталсан хөгжлийн зорилтуудыг хөйүлэн дэмжих зэрэг нь хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд НҮБ-ын оролцоог нэмэгдүүлэхийг шаарддаг. Хүний эрхийн хамгаалагчдын болоод НҮБ-ын суурин төлөөлөгчийн газруудын гүцэтгэх үүрэг, зорилго хоорондоо нягт холбоотой байдаг. 2003 онд Тусгай төлөөлөгч Хүний Эрхийн Хороонд танилцуулсан тайландаа НҮБ-ын олон ажилтан хүний эрхийг хамгаалагч байдаг бөгөөд хүний эрхийг хамгаалагчид ихэнхидээ улсынхаа дотор НҮБ-ын хамгийн гол хамтран ажилладаг түншүүд байдаг.<sup>12</sup>

Тийм ч учраас Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг НҮБ-ын систем бүхэлдээ, тэр дундаа тухайн улс дахь суурин төлөөлөгчийн газар дэмжиж байгаа нь НҮБ-ын амин чухал зорилтыг дэмжиж байгаа хэрэг юм.

---

<sup>12</sup> E/CN.4/2003/104, догол мөр 5, 54.

---

## 1. Үндэсний хэмжээнд

НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар Тунхаглалыг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцож, бүрэн эрхийнхээ хүрээнд хүний эрхийг хамгаалагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх ёстой. Дараахи тодорхой үйл ажиллагааг дурдаж болно:

- Тунхаглалыг хөхиүлэн дэмжих, түгээн дэлгэрүүлэх, нутгийн тухайн орны хэл рүү хөрвүүлэх, тунхаглалын заалтыг үндэсний хууль тогтоомжид оруулан батлах;
- НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар болон тухайн оронд үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийг хамгаалагчдын хооронд уулзалт зохион байгуулах (төрийн байгууллага болон иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах), уулзалтын үеэр хүний эрхийг хамгаалагчид НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хөтөлбөрүүдийн бүрэн эрхэд хамаарах хүний эрхийн тулгамдсан зовоосон асуудал, тэдгээрийн талаархи зөвлөмжөө танилцуулна;
- Тухайн оронд НҮБ-ын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа хүний эрхийг зөрчлийн талаар анхаарал тавьж, тэдгээр асуудлыг холбогдох төрийн байгууллагад уламжилна;
- ТББ-тай хамтран ажилладаг хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн үүрэг ролийг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын байр, техник хэрэгсэл тодруулбал, хурлын танхим зэргийг хүний эрхийн сургалт явуулахдаа ашиглахыг зөвшөөрөх;
- Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч болон НҮБ-ын Тусгай илтгэгчдийн гаргасан холбогдох зөвлөмжүүдийг анхааран үзэх. НҮБ-ын тухайн оронд ажиллаж буй багуудаас дараахи байгууллагууд хүний эрхийг хамгаалагчидтай илүү ойр дөт ажилладаг. (тухайн орон болоод байгууллагын онцлогоос хамаарна):
- НҮБ-ын Суурин төлөөлөгч буюу Суурин зохицуулагч;
- НҮБ-ын янз бүрийн төрөлжсөн байгууллага, хөтөлбөрийн тэргүүнүүд түүний дотор ОУХБ, ДДКГ, НҮБ ДОХХ, НҮБХХ, ЮНЕСКО, ХЭДКГ, НҮБХС, ЮНИФЕМ, ДЭМБ;
- Хөтөлбөрийн зохицуулагчид, хамгаалалтын болон хүний эрхийн ажилтнууд (нэн ялангуяа, ДДКГ, НҮБХС, ХЭДКГ болон ОУХБ);
- Иргэний нийгэмтэй хамтран ажиллах асуудал хариуцсан мэргэжилтнүүд;
- Сайн засаглалын асуудал хариуцсан мэргэжилтнүүд;
- Боловсрол, мэдээллийн кампанит ажил хариуцсан мэргэжилтнүүд.

---

## 2. Бүсийн болон олон улсын төвшинд

Бүсийн болон олон улсын төвшинд, НҮБ хүний эрхийг хамгаалагчдад маш их дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой юм. Үүнд дараахи тодорхой үйл ажиллагаа багтана:

- Ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт хүний эрхийг хамгаалагчдын тухай болон Тунхаглалын тухай багтаах;
- НҮБ-ын тухайн төрөлжсөн байгууллагын буюу хөтөлбөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчдын гүйцэтгэж буй үүрэг рольд дүн шинжилгээ хийж, тэрхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчдаас үзүүлж буй дэмжлэг туслалцааг хязгаарлаж байгаа бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох;
- Бодлогын баримт бичиг хүний эрхийг хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх талаар онцгойлон тусгах;
- НҮБ-ын аль нэг байгууллагын бүрэн эрхтэй холбоотой хүний эрхийн асуудлаар ажилладаг хүний эрхийг хамгаалагчдын бүс нутгийн байгууллага, сүлжээнүүдтэй хамтран ажиллах. Хүний эрхийг хамгаалагчдад ямар хамгаалалт хэрэгтэй байгааг олж мэдэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх;
- Тусгай төлөөлөгчийн хүний эрхийг хамгаалагчдын талаар гаргасан тайлан, зөвлөмжийг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, орон хариуцсан ээлтэст дамжуулан өгөх.

## Г. Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаа

Энэхүү гарын авлагад өмнө өгүүлсэнчлэн, хүний эрхийг хамгаалагчид төрийн захиргааны байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад олон салбарт ажилладаг байж болно. Тиймээс өмнөх А-В хүртэлх хэсэг хүний эрхийг хамгаалагчид төдийгүй төрийн, төрийн бус, засгийн газар хоорондын байгууллагуудад ч нэгэн адил хамаарна. Энэхүү сүүлийн хэсэгт хүний эрхийг хамгаалагчид бүлгээрээ юу хийж болох талаар зарим нэг саналыг багтаалаа.

### 1. Ажлын чанар

- Шударга ёс, ил тод байдлыг бий болгох, түүнийгээ хадгалах.
- Хүний эрхийн зөрчлийн талаар тайлагнах мэргэжлийн дадлыг бий болгох.
- Үнэн зөв тайлангаар дамжуулан итгэлцлийг бий болгох.

- 
- Бусад хүний эрхийн байгууллагууд адилхан өндөр хэм хэмжээг сахихад тус дөхөм үзүүлэх.
  - Тухайн улсын нөхцөл байдал, үндэсний хууль тогтоомж нь Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглал болоод олон улсын хүний эрхийн бусад гэрээ конвенцийг хүндэтгэн сахиж байгаа нөхцөлд хүний эрхийг хамгаалагчид өөрсдөө тэдгээр хууль тогтоомж, тухайлбал ТББ-ыг бүртгүүлэх журам зэргийг чанд мөрдөх.

## 2. Сургалт

- Өөртөө болон бусад нөхөддөө, мөн бусад хүмүүст, тухайлбал цагдаа, сэтгүүлч, багш нар болон олон нийтэд зориулан хүний эрхийн сургалт тогтмол зохион байгуулах. Хүний эрхийг хамгаалагчдад сургалтад явуулахдаа тэднийг үйл ажиллагаагаа мэргэжлийн болгох, мөн аюулгүй байдлын зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх талаар багтаах.
- Дээрх арга хэмжээнүүд нь хүний эрхийн асуудалд болон хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаанд олон нийтийн анхаарлыг хандуулах нэмэлт зорилгыг биелүүлж чадна.

## 3. Харилцаа холбооны сүлжээ буюу суваг

- Хүний эрхийг хамгаалагчдын дунд болон хэвлэл мэдээлэл, сүм, иргэний нийгэм, холбогдох хувийн хэвшлийн оролцогчидтой хамтарсан сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлэх. Сүлжээ нь ялангуяа, орон нутаг, үндэсний болон бүсийн төвшинд чухал бөгөөд олон улсын төвшинд ч мөн хэрэгтэй.
- Эдгээр сүлжээг хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдлыг хянах, эрсдэлд учраад байгаа хүний эрхийг хамгаалагчийн тухай мэдээллийг түргэн шуурхай дамжуулах, хамгаалагчид өргөн хүрээнд, хүний эрхийн бүхий л төрлийг төлөөлж чадаж байх зэрэгт ашиглаж болно. Хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл дамжуулахаар уг сүлжээг ашиглахдаа, хүний эрхийг хамгаалагчид гол хамтран ажиллагчаа тодорхойлохоос гадна мэдээллээ ашиглахад хялбар хэлбэрээр дамжуулах ёстой. Харилцаа холбооны эдгээр сувагт олон нийтэд мэдээлэл түгээх стратегийг багтааж болно.

---

#### 4. Дүн шинжилгээ

- Тухайн оронд хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй үндсэн бэрхшээлийг зөв тодорхойлох, тэдгээрийг хэрхэн даван туулах талаар эрх бүхий байгууллагад зөвлөмж өгөх.

#### 5. Хүний эрхийн асуудлаар төрөөс үзүүлэх хамгаалалтыг сайжруулах

- Дотоод хэргийн сайд, шүүгч, прокурор, цагдаагийн газрын дарга гэх мэт албан тушаалд хүний эрхийн сургалтад хамрагдсан хүмүүсийг томилохыг дэмжих.
- Хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэх, хамгаалах чиглэлээр төрийн болон бие даасан байгууллага байгуулахыг хөхиүлэн дэмжих.
- Засгийн эрх баригчдаас хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах ажлыг дэмжиж, ял шийтгэлгүй үлдэх явдлыг таслан зогсоохыг шаардах.

#### 6. Хамгаалалтын стратеги

- Хүний эрхийг хамгаалагчдад тулгарч байгаа аюул заналаас цаг алдалгүй хамгаалах стратеги, тактикийг тодорхойлох. Уг стратеги нь тухайн эрсдэлтэй нөхцөл байдлыг бүсийн буюу олон улсын хамгаалалтын сүлжээнд мэдэгдэх шаардлагатай эсэхийг тодорхойлох шалгуурыг багтаах ёстой бөгөөд хамгийн үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллийг дамжуулах учиртай.
- Хамгаалалтын стратеги нь тодорхой хэргийн талаар Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн тусгай төлөөлөгчид хэрхэн уламжлах тухай заах ёстой. Энэхүү гарын авлагын Хавсралт 2-т энэ тухай нэмэлт мэдээлэл бий.

#### 7. Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглалыг хэрэглэх

- Тунхаглалыг маш сайн хэрэглэх нь хүний эрхийг хамгаалагчдын стратегийн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой.
- Тунхаглалыг сургалтын кампанит ажлын үеэр түгээн дэлгэрүүлэх, сурталчилж болох бөгөөд хүний эрхийг хамгаалагчид Тунхаглалыг үндэсний хууль тогтоомжид оруулан батлах буюу түүнийг хэрэгжүүлэх орон нутгийнхаа онцлогт тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах зэргээр ажиллах боломжтой.

---

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1

**Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал**

*Ерөнхий Ассамблей,*

*Дэлхийн бүх орны хүн бүрт хүний бүхий л эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн НҮБ-ын Дүрмийн бүхий л зарчмуудыг дагаж мөрдөхийн чухлыг дахин баталж,*

*Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын болон хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн олон улсын хичээл зүтгэлийн үндсэн элементүүд болж нэгтгэгдсэн Хүний Эрхийн 2200 А (XXI) Тогтоолоорх Олон улсын гэрээний баримт бичгүүдийн ач холбогдлыг дахин баталж, мөн НҮБ-ын тогтолцооны хүрээнд болон мөн түүнчлэн бүс нутгийн түвшинд батлагдсан бусад хүний эрхийн баримт бичгүүдийн ач холбогдлыг дахин баталж,*

*Арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрөлтийн болон бусад статус зэрэг аливаа төрлийн ялгаваргүйгээр бүх нийтийн хүний эрх, эрх чөлөөг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжиж, зоригжуулах чухал үүрэг хариуцлагаа олон улсын нийгэмлэгийн бүх гишүүн орон хамтран болон тусдаа ханган биелүүлэх ёстой гэдгийг онцлон тэмдэглэж,*

*Дүрмээр хүлээсэн энэ үүргээ биелүүлэхийн тулд олон улсын хамтран ажиллахын онцгой ач холбогдлыг дахин баталж,*

*Хувь хүний болон хэсэг бүлэг хүмүүсийн хүний эрх, эрх чөлөөг зөрчих болон апартейд, арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэр, колоничлол, гадаадынхны эрх мэдэл болон эзлэн түрэмгийлэл, үндэсний тусгаар тогтнол руу дайрч довтлох, аюул занал учруулах, үндэсний эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал зэргээс улбаалан үүсч байгаа өргөн олныг хамарсан хүний эрхийн жигшин зэвүүцмээр байнгын бүхий л*



---

зөрчлүүдийг үр нөлөөтэй арилгах болон улс түмний өөртөө засан тогтнох эрх болон хүн бүрийн бүрэн тусгаар тогтносон орныхоо баялаг, байгалийн баялагийг ашиглах эрхтэйг татгалзахаас хүлээн зөвшөөрүүлэхэд олон улсын хамтын ажиллагааны гүйцэтгэх эрхэм үүргийн болон бие хүн, бүлэг болон эвсэл холбоодын явуулж байгаа үйл ажиллагааны зүгээс оруулах хувь нэмрийн ач тусыг санаж,

Олон улсын энх тайван ба аюулгүй байдал болон хүний эрх, эрх чөлөөгөө сэтгэл ханамжтай эдлэх хоёрын хоорондох харилцааг хүлээн зөвшөөрөн, олон улсын энх тайван ба аюулгүй байдал тогтоогүй байх нь зөвшилцөөнд хүрээгүйг зөвтгөхгүйг анхааран үзэж,

Хүний бүхий л эрх, эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай бөгөөд эдгээр эрх, эрх чөлөө бүрийг хөхиүлэн дэмжиж, хэрэгжүүлэхдээ шударга, өв тэгш байдлаар, ямарч хор хөнөөлгүйгээр хэрэгжүүлэх ёстойг дахин баталж,

Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хамгаалах нь Гишүүн орон бүрийн эн тэргүүний үүрэг хариуцлага мөн гэдгийг онцлон тэмдэглэж,

Бие хүн, бүлэг ба эвсэл холбоод нь үндэсний ба олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөний тухай мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих эрх ба үүрэгтэйг хүлээн зөвшөөрч,

Тунхаглаж байна:

#### 1 дүгээр зүйл

Хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй.

#### 2 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр, хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд бүх эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэхэд шаардагдах нийгэм, эдийн засаг, улс төрийн болон мөн хууль эрх зүйн баталгааг бүрдүүлж өгөхөд шаардагдах бүхий л нөхцөл байдлуудыг бий болгоход шаардлагатай алхмуудыг батлах замаар хүний бүхий л эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих болон хэрэгжүүлэх эн тэргүүний үүргийг хүлээнэ.

---

2. Оролцогч улс бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг үр дүнтэйгээр баталгаажуулсан байхад шаардлагатай хууль тогтоомж, захиргааны болон бусад алхамуудыг батлах ёстой.

### *3 дугаар зүйл*

НҮБ-ын Дүрмэнд нийцсэн дотоодын хууль, тогтоомж болон хүний эрх, эрх чөлөөний талбарт Гишүүн орны хүлээх бусад олон улсын үүрэг хариуцлага нь хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх хуулийн хүрээ болох бөгөөд хүний тэдгээр эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах болон хүндэтгэн биелүүлэхийн тулд энэхүү Тунхаглалд заасан бүхий л үйл ажиллагааг авч явуулах ёстой.

### *4 дүгээр зүйл*

Энэхүү Тунхаглалд заасан аливаа зүйл, заалтыг НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчмуудыг бууруулах, эсвэл үгүйсгэн няцаах байдлаар эсвэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүний эрхийн олон улсын Гэрээнүүдийн зүйл заалтуудыг болон бусад энэ талбар дахь олон улсын баримт бичиг болон харилцан зөвшилцсөн үүргийг хязгаарласан буюу басамжилсан байдлаар мушгин тайлбарлах ёсгүй.

### *5 дугаар зүйл*

Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хувь хүн бүр үндэсний болон олон улсын түвшинд хувиараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж:

- a) Тайван замаар хуран цуглах, цуглаан хийх
- b) Төрийн бус байгууллага, эвсэл холбоо болон бүлэгт оролцох, нэгдэх болон үүсгэн бий болгох
- c) Төрийн бус байгууллага болон засгийн газар хоорондын байгууллагуудтай харилцах эрхтэй байна.

### *6 дугаар зүйл*

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж:

a) Хүний бүхий л эрх, эрх чөлөөний тухай мэдээллийг, түүний дотор эдгээр эрх, эрх чөлөө нь дотоодын хууль тогтоомж, шүүхийн болон захиргааны тогтолцоонд хэрхэн тусгагдсан зэрэг мэдээллийг мэдэх, эрж хайх, олж авах, хүлээж авах болон хадгалах эрхтэй

b) Хүний эрхийн болон бусад холбогдох олон улсын баримт бичгүүдэд дурьдсаны дагуу хүний бүхий л эрх, эрх чөлөөний талаархи мэдлэг,

---

мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтлэх, бусдын үзэл бодолд нөлөөлөх, түгээн дэлгэрүүлэх эрхтэй

с) Хүний бүхий л эрх, эрх чөлөөний талаар эрх зүй болон бодит амьдралд мөрдөж баримталдаг үзэл бодолтой байх, суралцах, хэлэлцэх, эдгээр болон бусад тохиромжтой арга хэрэгслээр эдгээр үйл хэргүүдэд олон нийтийн анхаарлыг хандуулах эрхтэй.

### *7 дугаар зүйл*

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, хүний эрхийн талаархи шинэ ойлголт, зарчмуудыг хөгжүүлэн хэлэлцэх болон тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх эрхтэй.

### *8 дугаар зүйл*

1. Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, ямарч алагчлалгүйгээр өөрийн орны засгийн газрын үйл ажиллагаанд оролцох болон олон нийтийн үйл ажиллагааг удирдан явуулахад үр дүнтэйгээр оролцох боломжтой байх эрхтэй.

2. Мөн хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, Засгийн газрын байгууллага, агентлаг болон олон нийтийн үйл хэрэгт хамааралтай байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн биелүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахад саад болж болох тэдний ажлын аль нэг талд анхаарлыг нь хандуулах, тэдний явуулж байгаа үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн санал, шүүмжлэл танилцуулах эрхтэй.

### *9 дүгээр зүйл*

1. Энэхүү Тунхаглалд дурдагдсанаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зэргээр хүний эрх, эрх чөлөөг ханган биелүүлэх явцад эрх нь зөрчигдсөн тохиолдолд хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж үр дүнтэй арга хэрэгслээр хамгаалуулах эрхтэй.

2. Энэ зорилгоор, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хэн боловч өөрөө болон хуулийн дагуу эрх олгогдсон төлөөллөөрөө дамжуулан гомдол гаргах, гаргасан гомдлыг нь шударга, бие даасан, эрх бүхий шүүхээр эсвэл хуулийн дагуу байгуулагдсан бусад эрх олгогдсон байгууллагуудаар хэлэлцүүлэхээс өмнө нээлттэй шүүх хурлаар хойшлуулалгүй дахин хянуулах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн дагуу цагаатгагдах, тухайн хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөнд нөхөн төлбөр авах, мөн шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр эцсийн шийдвэр болгон хэрэгжүүлүүлэх эрхтэй.

---

3. Мөн энэ л зорилгоор хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж:

а) Төрийн албан хаагч болон засгийн газрын байгууллагуудаас явуулж байгаа хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн бодлого, үйл ажиллагааны талаар өргөдөл, хүсэлт болон бусад тохиромжтой арга хэрэгслээр дотоодын эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага, гүйцэтгэх захиргаа болон хуулийн байгууллага, эсвэл Гишүүн орны эрх зүйн тогтолцоогоор эрх олгогдсон бусад байгууллагад гомдол гаргах эрхтэй ба гомдолд гаргасан тэдний шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр ёсоор болгох ёстой.

б) Гаргасан гомдол нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын өмнө хүлээсэн холбогдох үүрэг хариуцлага болон харилцан зөвшилцсөн үүрэгтэй нийцсэн талаар санаа бодлоо илэрхийлэхийн тулд нээлттэй шүүх хурал, шүүн хэлэлцэх ажиллагаа, шүүх хуралд оролцох эрхтэй.

с) Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар мэргэжлийн хувьд мэргэшсэн хуулийн зөвлөх болон бусад холбогдох зөвлөгөө, туслалцаагаар хангах, санал болгох эрхтэй.

4. Мөн энэ л зорилгоор, олон улсын зохих баримт бичиг, журмын дагуу хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж, нийтлэг буюу тусгай эрх бүхий олон улсын байгууллагуудтай хүний эрх, эрх чөлөөний асуудлаар холбоо харилцаатай байх, саатуулагдашгүй боломжтой байх эрхтэй.

5. Улс бүр мөрдөн шалгалтыг цаг алдалгүй шударгаар явуулах ёстой буюу үйлдэгдсэн хүний эрх, эрх чөлөөний зөрчил нь аливаа газар нутагт тухайн орны шүүн таслах эрх мэдлийн хүрээнд хамаарна гэх үндэслэлтэй учир шалтгаан байсан хэдий ч асуулт байцаалтыг явуулсан байх ёстой.

#### *10 дугаар зүйл*

Дээрээс шаардсан шийдвэр тогтоолын дагуу хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдэлд хэн ч оролцох ёсгүй. Энэхүү үйлдлийг хийхээс татгалзсаныхаа төлөө хэн ч шийтгэгдэх ёсгүй.

#### *11 нэгдүгээр зүйл*

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, өөрийн мэргэжил албан тушаалаа хуулийн дагуу ашиглах эрхтэй. Мэргэжлийн дагуу хүний нэр

---

төр, хүний эрх, эрх чөлөөнд нөлөө үзүүлж чадах хэн боловч бусад хүний тэдгээр эрх, эрх чөлөөг нь хүндлэн сахих ёстой ба мэргэжлийн болон албан тушаалтны талаар холбогдох үндэсний болон олон улсын хэм хэмжээ, ёс зүйг дагаж мөрдвөл зохино.

### *12 дугаар зүйл*

1. Хүн бүр хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихийн эсрэг үйл ажиллагаанд тайван замаар оролцох эрхтэй.

2. Улс бүр, энэхүү тунхаглалд дурьдсан эрхүүдээ хууль ёсны дагуу эдлэн, хувиараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж, заналхийлэл, хариу арга хэмжээ, хуульд заагаагүй буюу хуульд заасны дагуу алагчлах, дарамт шахалт, бусад аливаа дур зоргоороо үйлдэл зэрэг аливаа хүчирхийллийн эсрэг тэмцсэн хэн бүхнийг эрх бүхий байгууллагаар хамгаалуулах бүхий л арга хэмжээг ханган хэрэгжүүлнэ.

3. Үүнтэй холбоотойгоор, хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн болон мөн хүний эрх, эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдлэхэд нь муугаар нөлөө үзүүлэх бүлэг буюу хувь хүний үйлдсэн хүний эрхийн эсрэг тайван замаар эсэргүүцэл үзүүлэх үйл ажиллагаа, үйлдлүүдэд хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, оролцсон хүн бүр үндэсний хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэйгөөр хамгаалагдсан байх эрх олгогдоно.

### *13 дугаар зүйл*

Хүн бүр хувиараа болон эвлэлдэн нэгдэж, Энэхүү Тунхаглалын 3-р зүйлийн дагуу тайван замаар хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах тусгай зорилгоор нөөц боломжийг шаардах, хүлээн авах болон ашиглах эрхтэй.

### *14 дүгээр зүйл*

1. Гишүүн орон нь өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд хүн бүрийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхүүдийн тухай мэдлэгээ дээшлүүлэхэд нь чиглэгдсэн хуулийн, шүүхийн болон гүйцэтгэх захиргааны болон бусад зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

---

2. Иймэрхүү арга хэмжээнүүд нь:

а) Хүчинтэй байгаа үндэсний хууль тогтоомж, журмууд болон холбогдох олон улсын хүний эрхийн үндсэн баримт бичгүүдийг хэвлэн нийтлэх

б) Олон улсын хүний эрхийн гэрээний байгууллагуудад Гишүүн орны тавьсан ээлжит илтгэлүүд, мөн хэлэлцсэн асуудлын товч бичиглэл болон эдгээр гэрээний байгууллагуудын албан ёсны илтгэлүүд зэрэг хүний эрхийн талбар дахь олон улсын бичиг баримтуудыг олж авах бүрэн, тэгш боломж

3. Гишүүн орон нь өөрийн шүүх эрх мэдлийн хүрээн дэх бүх нутаг дэвсгэрт омбудсман, хүний эрхийн комисс буюу үндэсний байгууллагын бусад аливаа хэлбэрийн хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний бие даасан хараат бус байгууллагуудыг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

#### *15 дугаар зүйл*

Гишүүн орон нь боловсролын бүх түвшинд хүний эрх, эрх чөлөөний тухай заахыг хөхиүлэн дэмжих, дэмжлэг үзүүлэх, мөн хуульчид, хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнууд, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон олон нийтийн ажилтнуудад хүний эрхийн сургалт явуулах хүмүүсээр хангах, тэдгээр нь хүний эрхийг заах сургалтын хөтөлбөртөө дээрх хүмүүсийн ажил үүрэгтэй холбоотой тохирох элементүүдийг багтаасан байх явдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ.

#### *16 дугаар зүйл*

Хувь хүн, төрийн бус байгууллагууд болон холбогдох байгууллагууд хүний эрхийн талбарт боловсрол олгох, сургалт, судалгааны ажил зэрэг үйл ажиллагаагаараа дамжуулан олон нийтэд хүний эрх, эрх чөлөөний талаар мэдлэг олгох, цаашилбал үндэстнүүд, арьсны өнгө болон шашны бүлэглэлүүдийн дунд ойлголцол, зөвшилцөл, энх тайван болон найрсаг харилцааг бэхжүүлэх, нийгмийн янз бүрийн давхаргад үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс санаа бодлоо хуваалцахад хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

#### *17 дугаар зүйл*

Хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа хүн бүр Энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ, зөвхөн холбогдох олон улсын үүрэг хариуцлагын дагуу болон гагцхүү

---

бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэм дэх хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуулиар тодорхойлогдсон зохих хязгаарлалтанд захирагдана.

#### *18 дугаар зүйл*

1. Хүн бүр бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангаж чадах нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээнэ.

2. Бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд ардчиллыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, ардчилсан нийгэм, байгууллага, үйл ажиллагааг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.


3. Мөн түүнчлэн бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн баримт бичгүүдэд заан тунхаглагдсан хүн бүр нийгэм, олон улсын эмх цэгцтэй байдалд байх эрхийг хөхиүлэн дэмжихэд боломжийн хирээр хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.

#### *19 дүгээр зүйл*

Энэхүү Тунхаглалын ямарч зүйлийг аль нэг улс орон, бүлэг буюу байгууллага, хувь хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг үгүйсгэхэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагаанд оролцох, тийм үйлдэл хийх эрх бололцоо олгож байгаа мэт мушгин тайлбарлаж болохгүй.

#### *20 дугаар зүйл*

Энэхүү Тунхаглалын ямарч зүйлийг Улс орны зүгээс бие хүн, байгууллага, төрийн бус байгууллагын аливаа НҮБ-ын Дүрмийн заалтуудтай харшилсан үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрсөн мэт мушгин тайлбарлаж болохгүй.



---

## Хавсралт 2

### Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалыг зөрчсөн үйлдлийн талаар Тусгай төлөөлөгчид гомдол гаргах зааварчилгаа

#### Зөв мэдээлийг сонгох, түүнийгээ тодорхой танилцуулах

- Гомдол гаргахаасаа өмнө А (Ерөнхий мэдээлэл) баганад дурдагдсан 1-7 зүйлүүд бүгдээрээ багтсан эсэхийг нягтлах хэрэгтэй. Маш яаралтай тохиолдолд эдгээр зүйлсээс заримыг дутуу явуулж болох боловч, энэ нь тухайн асуудлыг судлан үзэх ажлыг улам хүндрүүлнэ гэдгийг санах нь зүйтэй.
- Хэрэв танд нэмэлт мэдээлэл байгаа бол нэмэлт мэдээллийн жишээг Б баганаас харж болно. (Хэрэгтэй мэдээлэл). Эдгээр мэдээлэл заавал байх ёстой биш хэдий ч зарим тохиолдолд хэрэг болж болно.
- Мэдээллийг жагсаалт маягаар (А баганад дурдсан шиг), эсвэл захидалд дурдаж болно. В баганад тодорхой тохиолдлын тухай мэдээлэл, түүнийг хэрхэн захианд бичих талаар жишээ байгаа. Зөв мэдээлэл өгч, түүнийгээ тодорхой илэрхийлэх нь хурдан хариулт өгөх явдлыг хялбарчилдаг.

#### Нууцыг хадгалах

- Хохирогчийн нэр хаягийг Тусгай төлөөлөгч болон эрх баригчдын хоорондын аливаа харилцаа холбоонд заавал тусгах ёстой. Тусгай төлөөлөгч хохирогчийн нэр хаягийг тодруулалгүйгээр хөндлөнгөөс оролцож чадахгүй. Хэрэв хохирогч насанд хүрээгүй бол Тусгай төлөөлөгч түүний нэрийг харъяалах улстай нь холбоо барихдаа дурдах боловч олон нийтэд нээлттэй бусад ямар ч тайланд дурдахгүй. Мэдээллийн эх сурвалж болон хохирогч өөрөө олон нийтэд нээлттэй тайланд нэр хаягийг нь дурдахгүй байхыг хүсэж болно.
- Аливаа зөрчлийн тухай мэдээлэл авсан эх сурвалжийг өөрөө зөвшөөрөөгүй бол ямар ч тохиолдолд нууцлана. Мэдээллийг



---

хүлээлгэн өгөхдөө та нууц байлгахыг хүсч байгаа өөр ямар нэг зүйл байгаа эсэх талаар дурдах ёстой.

### Өргөдлөө илгээх буюу холбоо барих хаяг

- Тусгай төлөөлөгчийн ажлын алба хүсэлтийн дагуу өргөдлийг хүлээн авсан тухайгаа хариу мэдэгдэнэ. Тэдэнтэй хэдийд ч ахин харилцаж болно.
- Цахим шуудан: [urgent-action@ohchr.org](mailto:urgent-action@ohchr.org) Явуулах цахим шуудангийн агуулга хүний эрхийн хамгаалагчдын бүрэн эрхэд хамаарах асуудал байх ёстой.
- Факс: +41 22 917 9006 (Швейцарь улсын Женев хот)
- Утас: +41 22 917 1234. Энэ бол Швейцарь улсын Женев хот дахь НҮБ-ын байрны операторын дугаар юм.

Утсаар ярихдаа Хүний Эрхийн Хорооны асуудал хариуцсан НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Коммиссарын Газрын ажилтнуудтай, бүр тодруулбал Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгчийн ажлын албаныхантай холбогдохыг хүсэж буйгаа хэлэх хэрэгтэй.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

А Зайлшгүй мэдээлэл	Б Хэрэгтэй мэдээлэл	В Тусгай төлөөлөгчдөд илгээх захидлын загвар
<p><b>1. Хохирогчийн нэр</b> Овог нэрийг бичихдээ алдаагүй бичихийг анхаарах ёстой. Хувь хүн, бүлэг хүмүүс, эсвэл байгууллага хүний эрхийн зөрчлийн хохирогч байж болно.</p>	<p>Хэрэв тухайн хохирогч хувь хүн бол түүний нас, хүйс, иргэний харьяалал, ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгнө үү. Хэрэв хохирогч хувь хүн буюу байгууллага бол харилцах хаягийг бичнэ үү. Харилцах хаягийн нууцыг хадгална. Мөн боломжтой бол тухайн хохирогчийн (хувь хүн, байгууллагын) хүний эрхийн ажлаа явуулж байсан улс, хотыг тодорхой заана уу.</p>	<p>Хатагтай Аабб Ддее хуульч бөгөөд .....-д [улс, хотын нэр] үндэсний цөөнхийн шаардлага хангасан орон байраар хангагдах эрхийн төлөө өмгөөлөл хийдэг. Тэрээр өөрийн орны Хүний эрхийн зөвлөлийн гишүүн хүн юм.</p>
<p><b>2. Хохирогчийн хүний эрхийг хамгаалагчийн статус</b> Хохирогч (хүн, байгууллага) хүний эрхийн ямар үйл ажиллагаанд оролцдог вэ?</p>	<p>Хохирогчийн (хувь хүн, байгууллагын) хүний эрхийн ажлаа явуулж байсан улс, хотыг тодорхой заана уу.</p>	<p>.....[өдөр/сар/жил]-д Хатагтай Аабб Ддее .....дахь (хотын нэр) албан өрөөндөө нэгэн захидал хүлээж авлаа. Энэхүү захидлыг түүнд хаягласан бөгөөд зөвхөн “Болгоомжтой бай” гэсэн үгнээс өөр зүйл алга байв. Дараачийн өдөр нь Хатагтай Ддее гэр рүүгээ машинаараа явж байтал цагаан машинтай 2</p>
<p><b>3. Хохирогчдын эсрэг өдүүлсэн хүний эрхийн зөрчил</b> Юу болсон бэ? Хэзээ? Хаана? Одоо байдал ямар байна?</p>	<p><b>Гэрчүүд</b> Тухайн зөрчлийг харсан гэрч байгаа юу? Өөр ямар нэгэн хохирогч байгаа юу?</p>	<p>эрэгтэй хүн маш ойрхон дагаад байсан. Аабб Ддее тэр 2 хүнийг болон машинийг нь таньж чадаагүй бөгөөд түүнтэй хамт машинд явж байсан найз нь ч тэднийг машин дагаад байгааг харсан байна. Аабб Ддее энэхүү хоёр тохиолдлын тухай орон нутгийн цагдаагийн газарт [цагдаагийн газрын нэр, хаяг] тэр өдөрт нь мэдэгдсэн. Цагдаагийн</p>
<p><b>4. Зөрчил өдүүлэгчид</b> Зөрчил өдүүлэгчдийн талаар мэдэх бүх зүйлээ ярина уу. Жишээ нь, 2 эрэгтэй хүн (дүрэмт хувцастай байсан уу?); зэрэг дэв, анги салбар болон бусад таних тэмдэг эсвэл цол.</p>	<p><b>Хохирогч буюу хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаа</b> Тухайн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлсэн үү? Энэхүү мэдээллийг</p>	<p>Хохирогч буюу хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаа Тухайн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлсэн үү? Энэхүү мэдээллийг</p>
<p><b>5. Эрх баригчдын үйл ажиллагаа</b> Энэ асуудлын талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн үү? Ямар арга</p>	<p><b>Хохирогч буюу хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаа</b> Тухайн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлсэн үү? Энэхүү мэдээллийг</p>	<p>Хохирогч буюу хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаа Тухайн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлсэн үү? Энэхүү мэдээллийг</p>

хэмжээ авсан бэ? 6. Хүний эрхийн үйл ажиллагаа болон зөрчлийн хоорондох холбоо Яагаад та тухайн зөрчил хохирогчийн хүний эрхийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэж бодож байна вэ? Гарсан хүний эрхийн зөрчил бусад олон үйлдэлд хөтөлдөг учраас тэдгээрийг цаг хугацааны дарааллын дагуу тодорхойлно уу. Жишээ нь, хэрэв хүний эрхийг хамгаалагчийг баривчилсан бол тэр тухай бүх мэдээллийг гаргаж өгнө. Харин тухайн хүний эрхийг хамгаалагчийг баривчилсны дараа цагдан хорьсон бол хоригдож буй газар, тухайн хүн өмгөөлөгч авч чадсан эсэх, хорих байрны нөхцөл байдал, ямар хэрэг тулгаж байгаа зэрэг нэмэлт мэдээллийг гаргаж өгнө.

#### 7. Хэн энэхүү мэдээллийг өгсөн бэ? (Нууц)

Нэр, холбоо барих хаягаа бичих. Боломжтой бол мэргэжлийн үүрэг, хийж буй ажлынхаа тухай бичих.

Мэдээллийг хувь хүн буюу байгууллага өгч болно.

хүний эрхийн бусад байгууллагуудад явуулсан үү?

#### Өмнө болсон үйл явдал

Өмнө нь иймэрхүү үйл явдал тохиолдож байсан бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. Аабб Ддеегийн аюулгүй байдалд нэргүй заналхийлэл ирсэн. Бидэнд байгаа мэдээллээр

газар хэргийг бүртгэж авсан. Тэрээр мөн энэ явдлын тухай орон нутгийн сонинд мэдээлсэн. [сонинь нэр]. Нэг жилийн өмнө [огноо], Аабб Ддее тэй нэгэн адил үндэс угсаатай хуульч адилхан сүрдүүлсэн захидал авсан бөгөөд хэсэг хугацааны дараа үл таних хүмүүсийн гарт амт үрэгдсэн байна.

#### Мэдээллийг шинэчлэх

[хоёр сарын дараа] Шинээр авсан мэдээллээ Өнөөдөр [огноо] бид нэн даруй илгээж байна уу цагдаагийн байгууллага гэдэг чухал. Ялангуяа, мөрдөн шалгах ажлаа хохирогчийн нөхцөл өчигдрөөр дуусгавар байдалд ямарваа нэг болгосныг мэдлээ. Хоёр өөрчлөлт гарсан эсэхийг эрэгтэй хүнийг .....ний мэдэх нь туйлын чухал. Аабб Ддее Ддее сүрдүүлсэн захидал Дараахи тохиолдод явуулсан, түүний шинэчилсэн мэдээлэл өгч дараачийн өдөр ажлаасаа болно: тарахад нь машинаар - шинээр мэдээлэл олдох дагасан хэрэгт (жишээ нь, зөрчлийг өдүүлэгчийн нэр хаяг холбогдуулан 2 эрэгтэй тодорхой болсон бол); хүнийг баривчилсан - шинэ үйл явдал бөгөөд тэдний хэргийг хоёр тохиолдох (жишээ нь, долоо хоногийн дараа хохирогчийг хорионоос шүлхэнэ. Хатагтай Ддее хэдийгээр энэхүү суллах).

хуульч адилхан сүрдүүлсэн захидал авсан бөгөөд хэсэг хугацааны дараа үл таних хүмүүсийн гарт амт үрэгдсэн байна. [хоёр сарын дараа] Өнөөдөр [огноо] бид цагдаагийн байгууллага мөрдөн шалгах ажлаа өчигдрөөр дуусгавар болгосныг мэдлээ. Хоёр эрэгтэй хүнийг .....ний өдөр [огноо] Аабб Ддее сүрдүүлсэн захидал явуулсан, түүний дараачийн өдөр ажлаасаа тарахад нь машинаар дагасан хэрэгт холбогдуулан 2 эрэгтэй хүнийг баривчилсан бөгөөд тэдний хэргийг хоёр долоо хоногийн дараа шүлхэнэ. Хатагтай Ддее хэдийгээр энэхүү баривчилгаанд сэтгэл хангалуун байгаа ч тэдгээр хүмүүст захиалга өгсөн эзэн нь эрх чөлөөтэй явж байгаа хэмээн үзэж байна. Тиймээс тэрээр цагдаагийн байгууллага мөрдөн шалгах ажиллагаагаа үргэлжүүлэхийг хүссэн. Энэхүү захидлыг Аабб Ддеегийн ажилладаг Хүний эрхийн үндэсний хороо ирүүлсэн юм.

## Хүний эрхийн мэргэжлийн сургалтын цувралын жагсаалт

No. 2	The International Bill of Human Rights (Rev.1)	Олон улсын хүний эрхийн билл
No. 3	Advisory Services and Technical Cooperation in the Field of Human Rights (Rev.1)	Хүний эрхийн чиглэлд техникийн хамтын ажиллагаа, тусламж дэмлэг үзүүлэх нь
No. 4	Combating Torture (Rev.1)	Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь
No. 6	Enforced or Involuntary Disappearances (Rev.2)	Хүчээр сураггүй алга бологч
No. 7	Complaint Procedures (Rev.1)	Гомдол гаргах журам
No. 9	The Rights of Indigenous Peoples (Rev.1)	Уугуул иргэдийн эрх
No. 10	The Rights of the Child (Rev.1)	Хүүхдийн эрх
No. 11	Extrajudicial, Summary or Arbitrary Executions (Rev.1)	Хууль бусаар, дур зоргоор олноор нь цаазлах
No. 12	The Committee on the Elimination of Racial Discrimination	Арьсны өнгөөр алагчлахыг устгах асуудлаархи Хороо
No. 13	International Humanitarian Law and Human Rights	Олон улсын хүмүүнлэгийн хууль ба хүний эрх
No. 14	Contemporary Forms of Slavery	Боолчлолын орчин үеийн хэлбэр
No. 15	Civil and Political Rights: The Human Rights Committee (Rev.1)	Иргэний болон улс төрийн эрх: Хүний Эрхийн Хороо
No. 16	The Committee on Economic, Social and Cultural Rights (Rev.1)	Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Хороо
No. 17	The Committee against Torture	Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо
No. 18	Minority Rights (Rev.1)	Цөөнхийн эрх
No. 19	National Institutions for the Promotion and Protection of Human Rights	Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагууд
No. 20	Human Rights and Refugees	Хүний эрх ба дүрвэгсэд
No. 21	The Human Right to Adequate Housing	Зохистой орон байраар хангагдах эрх
No. 22	Discrimination against Women: The Convention and the Committee	Эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг: Конвенц ба Хороо
No. 23	Harmful Traditional Practices Affecting the Health of Women and Children	Хүүхэд болон эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх зан заншил, уламжлал

No. 24/Rev.1	The International Convention on Migrant Workers and its Committee	Цагаач ажилчдын тухай олон улсын конвенц ба түүний хороо
No. 25	Forced Evictions and Human Rights	Хүчээр нүүлгэн шилжүүлэлт ба хүний эрх
No. 26	The Working Group on Arbitrary Detention	Хууль бусаар баривчлан хорихын эсрэг ажлын хэсэг
No. 27	Seventeen Frequently Asked Questions about United Nations Special Rapporteurs	НҮБ-ын Тусгай Илтгэгчийн талаархи 17 асуулт, хариулт
No. 28	The Impact of Mercenary Activities on the Right of Peoples to Self-Determination	Ард түмний өөртөө засан тогтнох эрхэд үзүүлэх хөлсний этгээдүүдийн үйл ажиллагааны үр дагавар
No. 29	Human Rights Defenders: Protecting the Right to Defend Human Rights	Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалах эрхийг баталгаажуулах нь

---

Хүний эрхийн мэргэжлийн сургалтын цувралыг НҮБ-ын Женев дэх НҮБ-ын ХЭДКГ-аас эрхлэн гаргадаг.

Хүний эрхийн мэргэжлийн сургалтын цуврал нь НҮБ-аас хамгаалж, хөхиүлэн дэмжихээр зорьж буй хүний эрхийн асуудлаар үндсэн ойлголт өгөх, олон улсын хүний эрхийн механизмыг таниулах, хүний эрхийн тодорхой асуудлуудад хариулт өгөх зорилгоор хэвлэгддэг. Энэхүү мэргэжлийн цувралыг дэлхий даяар үнэгүй тараадаг бөгөөд товхимолуудыг эх хэл дээрээ агуулгыг нь өөрчлөхгүйгээр хэвлэн гаргахыг НҮБ дэмждэг. Хэвлэлийнхээ нэг хувийг НҮБ-ын Женев дэх төвд (доорхи хаягаар) илгээснээр чөлөөтэй иш татаж, дахин хэвлэж, олшруулж болно.

Хаяг:

Office of the United Nations High Commissioner for Human rights  
United Nations Office at Geneva  
8-14, Avenue de la Paix  
1211 Geneva 10  
Switzerland

New York, NY 10017  
United States of America

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН